



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

***Монгол дахь авилгалын
асуудалд холбогдох***

НОМ ЗҮЙ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар
2005 он

DDC
364.165'001
M-692

НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48,
Монгол Улс
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб хуудас: <http://www.forum.mn>

*Энэхүү ном зүйн судалгаа нь зөвхөн тайланг бэлтгэсэн зохиогчдын үзэл бодол,
тайлбарыг агуулсан бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын байр суурийг
илэрхийлээгүй болно.*

© Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэхийг хүсвэл ННФ-ын
хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

УНН.МН
СУДАЛГААНЫ САН

ISBN 99929-83-27-2

НОМ ЗҮЙГ ТОЛИЛУУЛАХ УЧИР

Нээлттэй Нийгэм Форум нь үйл ажиллагааныхаа чиглэл бүрт холбогдох, бүхий л эх сурвалжийг аль болох багтаасан ном зүйн цуврал гаргаж, тухайн сэдвээр судалгаа хийдэг гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид, төрийн болоод төрийн бус байгууллагын ажилтнууд, оюутан сурагчид, бодлого боловсруулагчид, хандивлагчид, сонирхсон хэн бүхэнд хүргэхийг зорьдог. Эдгээр цуврал ном зүйн удаахи болох “Монгол дахь авилгалын асуудалд холбогдох ном зүй” - г та бүхэнд толилуулж байна. Авилгалтай тэмцэх сэдэв нь Нээлттэй Нийгэм Форумын үйл ажиллагааны нэгэн тэргүүлэх чиглэл юм.


Монгол дахь авилгалын асуудалд холбогдох бүх эх сурвалжийг багтаасан энэхүү анхны ном зүй нь авилгалын нөхцөл байдал, авилгалтай тэмцэж буй бодлогыг сайжруулахад эх сурвалж, мэдээлэл бий болгох зорилготой. Авилгалын асуудал нь Монгол улсад өнөө үед хурцаар тавигдан, улмаар авилгалтай тэмцэх бодлогын шинэчлэл хийгдэх гэж буйтай холбогдуулан энэхүү ном зүй нь цаг үеэ олсон, ач холбогдол бүхий гэдэгт найдаж байна.

Ном зүйд урьд өмнө хийгдэж байсан, монгол, англи хэлээр хэвлэгдсэн эрдэм шинжилгээний ажил, судалгаа, илтгэл, сонины нийтлэл, ном, эмхэтгэл зэргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл багтсан.

Нээлттэй Нийгэм Форумын захиалгыг амжилттай гүйцэтгэж энэ номыг Таны гарт хүргэх бололцоо олгосон Зориг сангийн хамт олонд талархлаа илэрхийлье.

Энэхүү ном зүйн чанар, агуулгатай холбоотой санал хүсэлтийг osf@soros.org.mn хаягаар бид дуртайяа хүлээн авах болно.

П.Эрдэнэжаргал



Нээлттэй Нийгэм Форумын

Гүйцэтгэх захирал

ОИИ.МН
СУДАЛГААНЫ САН

ӨМНӨТГӨЛ

Авилгал өнөөгийн Монголын нийгмийн хамгийн ноцтой, хамгийн тулгамдсан асуудал болоод байгааг хүн бүхэн хүлээн зөвшөөрч байна. Улс орны маань хөгжлийг боогдуулан, хордуулж байгаа авилгалтай цаг алдалгүй, шийдвэртэй тэмцэх явдал хамгаас чухал болоод байгаа нөхцөлд “Авилгалын асуудалд холбогдох ном зүй”-г Монголд анх удаа гаргах туйлын зөв зүйтэй, хэрэгтэй ажлыг Нээлттэй Нийгэм Форумас санаачилсан явдлыг талархан хүлээж аваад бид энэхүү номыг уншигч авхай танаа толилуулаж байна.

Ном зүйг бүрдүүлэхдээ цаг хугацааны хувьд 1990 оноос өнөөдрийг хүртэлх хугацааг хамарсан бөгөөд аль болох олон эх сурвалж ашиглах, авилгалын олон талыг хамрах, хэрэглэхэд дөхөм хэлбэрт оруулахыг чармайсан болно. Материал авсан эх сурвалжуудын заримаас дурдвал: Улсын төв номын сан, Шинжлэх Ухааны академи, Их, дээд сургуулиудын номын сан, Шинжлэх ухаан, мэдээллийн паркын номын сан, Нээлттэй Нийгэм Форумын Хөгжлийн Мэдээллийн Төв, Улсын Их Хурлын номын сан /архив/, Удирдлагын академи, Хууль зүйн үндэсний төв, Улс төрийн боловсролын академи, Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын номын сан, Зориг сан болон авилгалтай тэмцэх чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд, НҮБ, гадаадын ЭСЯ болон төрийн бус байгууллагууд зэрэг юм. Интернетээс хайлт хийж мянга гаруй нэгжээс шүүлт хийн URL хаягийн хамт оруулсан болно. Ном зүйд оруулсан бүтээлүүдтэй судалгааны багийнхан нэг бүрчлэн танилцаж товч агуулга, тайлбарыг бичиж боловсруулсан юм.

Ном зүйг эмхэтгэн бэлтгэсэн баг:

1. С.Баяраа /Зориг сангийн зөвлөх/
2. Д.Ламжав /”Цэх” төрийн бус байгууллагын тэргүүн/
3. Н.Баяраа /ШУА-ийн Философи, социологийн хүрээлэнгийн ЭША/
4. О.Цэрэннадмид /Зориг сангийн гүйцэтгэх захирал/
5. Ч.Батбямба /Зориг сангийн төслийн ажилтан/

Хянан тохиолдуулсан:

- Ц.Ганболд Доктор, (PhD), профессор
Ж.Баярцэцэг, ННФ-ын менежер

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НОМ ЗҮЙГ АШИГЛАХ ЗААВАР

Ном зүйд орсон материалуудыг “I Авилгалын тухай ерөнхий сэдэв”, “II Авилгал ба засаглал”, “III Авилгал ба иргэний нийгэм”, “IV Авилгал ба хувийн хэвшил”, “V Авилгал ба хэвлэл мэдээлэл” гэсэн ерөнхий таван бүлэгт хувааж нэгдсэн дарааллаар байрлуулсан. Ном зүйн төгсгөлд байгаа хавсралтаас ном зүйд орсон материалын талаархи товч мэдээллийг зохиогч / хэвлэн нийтлэгчийн нэрсийн цагаан толгойн дарааллаар хүснэгтэд оруулсан хувилбарыг харж болно. Дараах жишээн дээр ном зүйд орсон материалыг нэгэн загвараар хэлбэржүүлсэн байдлыг үзүүлэв:

(1) 008.

(2) Хүний Эрхийн Үндэсний Комисс, (3) 2002. (4) “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл, 2002 он”.

(5) Ном, (6) 102 хуудас, (7) монгол

(8) Уг номыг Монголын ХЭҮК бэлтгэн, НҮБХХ/ Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар (ХЭДКГ)-ын хамтарсан МОН/01/103 төслийн хүрээнд, 2003 онд “Хаан Принтинг” ХХК-д хэвлүүлжээ. Утас: 262902, 262971, E-mail: contact@nhrc-mn.org, Вэбсайт: <http://www.nhrc-mn.org>

(9) НҮБ-ын санхүүжилтээр хийгдсэн “Хүний эрхийн үндэсний хөтөлбөр боловсруулах” төслийн хүрээнд 2001 оны 5-8-р сард “Хүний эрхийн төлөв байдал”-ын судалгаа нь уг илтгэлийн суурь болсон ажээ. Энэхүү судалгааг нийслэл болон бүх аймагт, 127 сум, 8822 өрх, 579 аж ахуйн нэгж байгууллага, 60 шахам мянган иргэдийг хамруулан хийжээ. Уг судалгааны дүнг 2001 онд олон улсын хүний эрхийн өдрөөр олон нийтэд зориулан хэвлүүлэн тараажээ.

(1) ----- Материалын нэгдсэн дугаар

(2) ----- Зохиогч / Хэвлэн нийтлэгч

(3) ----- Нийтэлсэн он

(4) ----- Материалын гарчиг

(5) ----- Материалын төрөл

(6) ----- Хуудасны хэмжээ

(7) ----- Ямар хэл дээр байгаа

(8) ----- Материалын гарал үүслийн /эх үүсвэрийн талаархи мэдээлэл

(9) ----- Материалын товч агуулга, тайлбар

ТОВЧИЛСОН ҮГС ИЙН ЖАГСААЛТ


Монголоор тогтвортой хэрэглэгддэг		Англиар тогтвортой хэрэглэгддэг	
Товчлол	Дэлгэрэнгүй	Товчлол	Дэлгэрэнгүй
ТИ	Транспаренси Интернейшнл	TI	Transparency International
ТББ	Төрийн бус байгууллага	NGO	Non-Governmental Organization
МННХ	Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн	MFOS	Mongolian Foundation for Open Society
ННФ	Нээлттэй Нийгэм Форум	OSF	Open Society Forum
ХАБХСЗ	Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр	GGHS	Good Governance for Human Security program
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр	UNDP	United Nations Development Program
ҮШЁТ	Үндэсний шударга ёсны тогтолцоо	NIS	National Integrity System
ЮНЕСКО	НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага	UNESCO	United Nation's Education Science and Culture Organization
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага	OECD	Organization for Economic Cooperation and Development
ЕХ	Европын Холбоо	EU	European Union
АБХОУТ	Ашгийн бус хуулийн олон улсын төв	ICNL	International Center for Not for Profit Law
ЛЭОС	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан	LEOS	Liberal Women's Brain Pool
АШСТО	Ардчиллыг шинээр буюу сэргээн тогтоосон орнууд	NRD	New and Restored Democracies
БНТХ	Байгаль орчин ба нийгмийн тогтвортой хөгжил		
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар		
АСТОУХ	Ардчилал болон сонгуульд туслах олон улсын хүрээлэн	IDEA	Institute for Democracy and Electoral Assistance
УИХ	Улсын Их Хурал	SGH	State Great Hural

Монголоор тогтвортой хэрэглэгддэг		Англиар тогтвортой хэрэглэгддэг	
Товчлол	Дэлгэрэнгүй	Товчлол	Дэлгэрэнгүй
МХХ	Монголын Хэвлэлийн Хүрээлэн	PIM	Press Institute of Mongolia
МУИС	Монгол Улсын Их Сургууль	NUM	National University of Mongolia
ХЭДКГ	Хүний Эрхийн Дээд Комиссариатын Газар	OHCHR	Office of High Commissioner of Human Rights
ХЭҮК	Хүний Эрхийн Үндэсний Комисс	NHRC	National Human Rights Commission
ААШДХ	Азид Ардчилал Шинэчлэлийг Дэмжих Холбоо	ARDA	Alliance for Reforms and Democracy in Asia
БНОУХ	Бүгд найрамдахчуудын Олон улсын хүрээлэн	IRI	International Republican Institute
ЗДТГ	Засаг даргын тамгын газар		
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал		
ТӨХ	Төрийн өмчийн хороо	SPC	State Property Committee
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар		
УТБА	Улс төрийн боловсролын академи		
ҮХБХ	Үндсэн хуулийн ба хууль эрх зүйн бодлогын хүрээлэн	COLPI	Constitutional and Legal Policy Institute
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхим		

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ГАРЧИГ

Өмнөх үг	iii
Ном зүйг ашиглах заавар	iv
Товчилсон үгсийн жагсаалт	v
1. АВИЛГАЛЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ СЭДЭВ	5
001. Авилгалын эсрэг сурвалж бичиг	7
002. Авилгал: түүний тухай ойлголт, тэмцэх арга зам	7
003. Үндэсний шударга ёсны тогтолцоо, түүний үзүүлэлтүүд	8
004. Монгол Улсын Авилгалтай Тэмцэх Үндэсний Хөтөлбөр	8
005. Хээл хахуулийн гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн үндсэн шинж	8
006. Криминологийн зарим асуудал	9
007. Хээл хахуулийн гэмт хэрэгтэй явуулах тэмцлийн зарим асуудал	9
008. Европын холбоонд элсэх үйл явцыг хянах нь: Европын холбоонд шинээр элсэн орсон Зүүн Европын гурван улсын авилгал ба авилгалтай тэмцэх бодлого	9
009. Авилгалын эсрэг НҮБ-ын конвенци, 2005	10
010. Коррупцийн ойлголт, мөн чанар	10
011. “Монгол дахь авилгалын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурь”, социологийн судалгааны тайлан	11
012. “Монгол дахь авилгалын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурь” социологийн судалгааны тухай товч мэдээлэл	11
013. Монгол дахь авилгал, түүнтэй тэмцэх арга зам	12
014. Албан тушаал, хээл хахуулийн гэмт хэргийн байдал, цаашид анхаарах асуудал	12
015. Үндэсний Шударга Ёсны систем, судалгааны тайлан	13
016. Монголд авилгал хар тахал болтлоо хүчирхэгжсэний шалтгаан, түүний хор уршиг	13
017. Улс төрийн хүрээний авилгалын индекс	14
018. Авилгалын индекс	14
019. Авилгалын мөн чанар, түүний үр дагаврын асуудал	14
020. Авилгалтай тэмцэх эрүүгийн эрх зүйн асуудал	15
021. Дэлхийн Авилгалын Тайлан 2004: Улс төрийн авилгал	15
022. Авилгалын эсрэг бодлого Ази, Номхон Далайн орнуудад, Монголын Улсын авилгалын өөрийн үнэлгээ	16
023. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл, 2002 он ..	16
024. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл, 2003 он...	17
025. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл 2004	17
026. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл 2005	18
027. Монголын сонгогчдын санаа бодлын судалгаа 2004 оны 4-р сар	19
028. Монголын сонгогчдын санаа бодлын судалгаа 2005 оны 1-р сар	19
029. Монголын сонгогчдын санаа бодлын судалгаа 2005 оны 5-р сар	20
030. Монгол улс дахь авилгалын байдалд хийсэн үнэлгээний тайлан 2005 он	20



031. Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын хандлага	21
032. Авилгалын өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ, дүгнэлт	21
033. Авилгалтай тэмцэх ба шударга ёсыг хамгаалах дэлхийн 3-р чуулганд ХЗДХЯ-ны сайдын тавьсан илтгэл	22
034. Авилгалын эсрэг хуулийн төслүүд	22
035. Авилгалын эсрэг Монгол Улсын хууль	22
036. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр	23
037. Ажлын хэсэг байгуулах тухай	23
038. Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл	23
039. Авилгалын эсрэг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал	24
040. Авилгалтай тэмцэх Монгол Улсын үндэсний төлөвлөгөөний баримт бичиг	24
041. Авилгалтай тэмцэх Монгол Улсын Үндэсний Хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн баримт бичиг	25
042. Ардчиллыг танилцуулахуй	25
043. Эрх баригчдын эрмэлзэл, олон нийтийн оролцоо л авилгалыг хязгаарлаж чадна.	26
044. Авилга авагчдын айх булчирхайг ажилладаг болгоё	26
045. Авилгал буух эзэнгүй “нисч” явна.	26
046. Авилгаар ажлаа бүтээе гэж байгаа бол гараа тат	27
047. Монголын нийгэмд тогтолцооны авилга нүүрлэсэн үү?	24
048. Монголд хүнд суртлын авлига ноёрхдог	27
049. Зөвхөн Африк болон Монголд л байдаг авилгын нэгэн хэлбэр	28
050. Авилга танд хоол болохгүй	28
051. Авилгалын эсрэг тэмцэлд хүч нэмэхүй	29
052. Авилгалд автагдсан Монгол	29
053. Авилгалтай тэмцэх монгол ухаанаа сэтгэж олъё	29
054. Авлига устав уу, авдаг, өгдөг нь нарийсав уу?	30
055. Авилгач “хорхойнууд”	30
056. Та авилга авдаг уу, өгдөг үү?	30
057. Авилгалтай тэмцэх онцгой загвар	30
058. Авилгалын үнэр	31
059. Авилгалд гарц байна уу?	31
2. АВИЛГАЛ БА ЗАСАГЛАЛ	33
060. Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр”-ийн бодлогын баримт бичиг	35
061. Хяналт-шинжилгээ, үнэлгээ: Шалгуур үзүүлэлт, явц, үр дүн	35
062. Төрийн албаны талаарх хууль, эрх зүйн актын эмхэтгэл	36
063. “Сайн засаглал” олон улсын бага хурлын илтгэлүүд	36
064. Иргэн түншлэгч болох нь: Бодлого боловсруулах явцад мэдээлэх, зөвлөлдөх, олон нийтийг оролцуулах	37
065. Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхтгэл	37
066. Засаглалын нэр томъёоны тайлбар	38
067. Сайн засаглал судалгааны тайлан	38
068. Ардчилалд үнэлгээ өгөх гарын авлага	38
069. Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа хөтөлбөрийн үр дүн, цаашдын хандлага ..	39

070. Зүүн Азийн Барометр 2005 он	39
071. Жон Куа, 1998. “Авилгалын эсрэг тэмцэх Монгол Улсын үндэсний төлөвлөгөө”	40
072. Үндэсний Шударга Байдлыг Дэмжихэд Донор орнууд болон Байгууллагуудын Тусалцаа	41
073. Авилгалын эсрэг үндэсний стратеги боловсруулах нь: Шилжилтийн эдийн засгийн жишээ	41
074. Авилгалын эсрэг тэмцэх үндэсний хөтөлбөр	42
075. Де.Спевиаль, 1999. “Авилгалын эсрэг тэмцэх Монгол Улсын Үндэсний төлөвлөгөө”	42
076. Де.Спевиаль, 1999. “Авилгалын эсрэг Дээд Комиссын тухай хуулийн төсөлд өгсөн зөвлөмж”	43
077. Де.Спевиаль, 2000. “Монгол Улсын Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр”	43
078. АХБ, Ази-Номхон далайн Авилгалын эсрэг Санаачлага, Ази-Номхон далайн Авилгалын эсрэг Үйл ажиллагааны төлөвлөгөө	44
079. Авилгал ба төрийн албан хаагчид	44
080. Монголд нүүрлээд буй Шүүхийн Авилгалын талаархи зарим асуудлууд	45
081. Авилгалын эсрэг цуврал уулзалт, ярилцлагын товч тэмдэглэл	45
082. Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахын эсрэг авах арга хэмжээ	46
083. АНУ-Монголын харилцаа: Олон талт харилцааг хөгжүүлэх шинэ үе	46
084. Авилгалын Эсрэг, Практик Мэдээлэл, Эцсийн хувилбар	47
085. Олон улсын хөгжлийн хүрээлэн, Монгол дахь засаглалын судалгаа, 2000 он ..	47
086. Дэлхийн Банк, Засаглалын асуудлууд III: Засаглалын шалгуур үзүүлэлтүүд ...	48
087. Хувьчлал дахь авилгал, шилжилтийн үеийн Монгол дахь авилгалын эсрэг үр дүнтэй стратеги төлөвлөгөө	48
088. Хуулийн байгууллагуудын үйл ажиллаганы ил тод, нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэх нь	49
089. Монгол улсын үндсэн хуулийн цэцгийн шийдвэрийн эмхэтгэл I,II	49
090. Авилгалын Эсрэг Хуулийн төсөл яагаад батлагдахгүй хоёр жил хойшлогдох болов оо?	50
091. Авилга өгдөг, авдаг тодорхой хүмүүсийг шалгаж байна	50
092. Авилгал бол эдийн засгийн чадавхийг сульдаагч	51
093. Боловсрол дахь авилгыг хэн өөгшүүлдэг вэ?	51
094. Шүүх, гааль авилгалд өртдөг үү?	51
095. Улс төрийн хүрээний Авлига сонгуулиас эхэлдэг	52
096. Авилгалтай хэрхэн тэмцэх вэ?	52
097. Авилга илчлэгддэггүйн гол гогцоо нь хуульдаа байгааг амьдрал харуулж байна ..	52
098. Эвслийн засгийн газар авилгалтай хэрхэн тэмцэх бол	53
099. Авилгал, ядуурал хоёр ихэр юм шүү	53
100. Авлигын эсрэг хуультай болъё гэдэг мөртлөө... ..	53
101. Авилгалтай тэмцэх алтан боломж яг одоо л байна	54
102. Монголд авилга байгаад зогсохгүй улам томорч байна	54
103. Монгол улсад нэг сая 200 мянган хүн авилгал авдаг	55
104. Авилга залилангийн арга улам нарийсч, олшрох хандлагатай байна	55
105. Миний ял, гавьяаг хоёрыг хойч үе шүүнэ	55



3. АВИЛГАЛ БА ИРГЭНИЙ НИЙГЭМ	57
106. 2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг	59
107. Нийгмийн хариуцлага: Үзэл баримтлал, шинээр гарч буй практик	59
108. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (мониторингийн судалгаа)	60
109. Авилгалтай тэмцэхэд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх нь	60
110. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нээлттэй байдал-иргэдийн оролцоо	61
111. Монголын Нээлттэй Нийгмийн Хүрээлэнтэй хамтран Авилгалын Эсрэг боловсролын кампанит ажлыг эхлүүлэхэд туслах томилолтын тайлан ...	61
112. Хүний эрхийн стратегийн нөлөөлөл: Туршлага ба амжилт	61
113. Эрдэмтнийг дэмжсэн иргэний үг	62
4. АВИЛГАЛ БА ХУВИЙН ХЭВШИЛ	63
114. Хувьчлал: түгээмэл асуулт, бодитой хариулт	65
115. Монгол Улс: Бизнесийг дэмжих таатай орчны бүрдүүлэлтийн судалгаа, 2004	65
116. Бизнесийн хүрэн дахь авилгал	66
117. Монгол улсын албан бус секторын хамрах хүрээ, төлөв байдал	66
118. Авилгалын эдийн засгийн өртөг	67
119. Олон улсын Бизнесийн үйл ажиллагаанд гадаадын төрийн албан тушаалтныг хахуульдах явдалтай тэмцэх тухай Конвенци	67
5. АВИЛГАЛ БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ	69
120. 2005 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн хэвлэл мэдээллийн мониторингийн дүн	71
121. Төрөө завхруулж, түмнээ хуурсан шаштир- I, II	71
122. Хэрхэн эрэн сурвалжлага хийх вэ?	71
123. Ерөнхийлөгчийг огцруулсан сэтгүүлчийн нөр их хөдөлмөр	71
124. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй -1	72
125. Эрэн сурвалжлах сэтгүүл зүй-2	72
126. Авилгалын эсрэг тэмцэлд ТББ-уудын оролцоог нэмэгдүүлэх нь	73
127. Авилгалын эсрэг тэмцэлд хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоог эрчимжүүлэх нь	73
128. Өнөөдөр эсвэл хэзээ ч	73
МАТЕРИАЛЫН АНГИЛАЛ	75

1

АВИЛГАЛЫН ТУХАЙ
ЕРӨНХИЙ СЭДЭВ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

001.

Жереми Поуп, 2000. “Авилгалын эсрэг сурвалж бичиг”

Ном, 450 хуудас, монгол, орчуулга

2000 онд ТИ олон улсын ТББ-аас эрхлэн гаргасан TI Source Book 2000, “Confronting Corruption: The Elements of a National Integrity System”, Author: Jeremy Pope хэмээх номыг бичиж боловсруулах ажлыг ТИ-г үндэслэгч бөгөөд авилгалын талаарх мэдээлэл, мэдлэгийн менежментийг хариуцагч Жереми Поуп хариуцан гүйцэтгэсэн аж. Уг номыг олон нийт маш ихээр талархан хүлээн авснаар дэлхийн 20 орчим орны хэл дээр орчуулагдан хэвлэгджээ. Тус номыг 2003 онд Монголын Засгийн Газрын ХАБХСЗ хөтөлбөрийг дэмжих төслийн хүрээнд Монголын судлаач, шинжээчдийн оролцоотойгоор, НҮБХХ-ийн санхүүжилтээр, монгол хэл дээр орчуулан Тоонотпринт ХХК-д хэвлэжээ. Номын эхийг ТИ-ийн www.transparency.org вэбсайтад байрлуулсан ба байнга засварлан баяжуулж байна. Зохиогчтой jeremypope1@compuserve.com, монголын талын хариуцагчтай gghspmu@mongol.net хаягаар тус тус харицаж болно.

Энэ номоос дэлхий даяар өрнөж буй Авилгалын эсрэг тэмцэлд оруулж ирсэн “Үндэсний шударга ёсны тогтолцоо” хэмээх цоо шинэ үзэл баримтлалтай танилцах, мөн дэлхийн олон улсад хэрэгжүүлж байгаа шинэ санаачлага, туршлагаудын талаар мэдээлэл авах боломжтой. Тус ном нь авилгалын эсрэг үйл ажиллагаа явуулж байгаа аливаа байгууллага, хүмүүс, судлаач шинжээчдэд гарын авлага болон ашиглагдаж, цаашид энэхүү үйл ажиллагаагаа иргэний нийгмийн оролцоотойгоор зохистой явуулахад онол-практикийн найдвартай зөвлөгчийн үүргийг гүйцэтгэнэ.

002.

Зориг сан, 2000. Авилгал: түүний тухай ойлголт, тэмцэх арга зам /семинарын эмхэтгэл/

Ном, 40 хуудас, монгол

Зориг сангаас Азийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Авилгал ба төрийн албан хаагчид” төслийн хүрээнд Засгийн Газрын ХЭГ-тай хамтран шинээр томилогдсон төрийн албан хаагчдын дунд 2000 оны 11 сарын 20, 27, 12 сарын 4-ний өдөр гурван удаа семинар зохион явуулсан байна. Тус сан эдгээр семинар дээр тавигдсан илтгэлүүдийг эмхтгэн нийтлүүлжээ. Энэхүү нийтлэлийг Зориг сангийн номын сан болон www.zorigfoundation.org.mn вэбсайтаас танилцаж болно.

Энэхүү номонд семинар дээр уншигдсан “Авилгал ба улс төр”, “Авилгал ба эдийн засгийн реформ”, “Авилгал ба нийгмийн ёс суртахуун”, “Авилгалтай тэмцэх арга зам” лекцүүдээс гадна ТИ-гээс 1998-2000 онд гаргасан дэлхийн улсуудын Авилгалын индексийг оруулсан байна. Энэ ном нь авилгалын эсрэг нийгмийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн зорилготой.

003.**Хүний Аюулгүй Байдлыг Хангах Сайн Засаглал Хөтөлбөр (ХАБХСЗ),
2003. “Үндэсний шударга ёсны тогтолцоо, түүний үзүүлэлтүүд”**

Ном, 228 хуудас, монгол

Энэ номыг Монголын Засгийн Газрын ХАБХСЗ хөтөлбөрийг дэмжих төсөл хариуцан, “Тоонотпринт” ХХК-д НҮБХХ-ийн санхүүжилтээр хэвлүүлжээ. Имэйл: gghsprmu@mongol.net

Номын “Үндэсний шударга ёсны тогтолцоо” хэмээх эхний бүлэг, “Үндэсний шударга ёсны тогтолцооны үзүүлэлтүүд” хэмээх эцсийн бүлэг хоёроос бусдыг НҮБХХ-өөс гэрээлсэн Монголын 15 мэргэжилтэн боловсруулсан байна. Монголын ҮШЁТ-ны талаарх энэ ном бол мэргэжилтнүүд нь холбогдох асуудлын талаар өөрсдийн байр суурийг хийсэн судалгаа, ажиглалтынхаа үндсэн дээр хараат бус байдлаар илэрхийлсэн анхны оролдлого юм. Номын эхний бүлэгт ҮШЁТ-ны тухай ойлголтыг, эцсийн бүлэгт ҮШЁТ-ны харьцуулсан үзүүлэлтүүдийг “TI Source Book 2000” буюу “Авилгалын эсрэг сурвалж бичиг” номд туурвисан үзэл баримтлалын дагуу товч өгсөн.

004.**Хүний Аюулгүй Байдлыг Хангах Сайн Засаглал Хөтөлбөр (ХАБХСЗ), 2003.
“Монгол Улсын Авилгалтай Тэмцэх Үндэсний Хөтөлбөр”
“Mongolian National Program for Combating Corruption”**

Ном, 12 хуудас, монгол, англи

Монгол Улсын Засгийн газрын ХАБХСЗ хөтөлбөрөөс 2003 онд зохион байгуулсан “Авилгалын эсрэг үндэсний бага хурал”-ын материал дотор тараагдсан товхимол. Утас/факс: 320177, 320342, Имэйл: gghsprmu@mongol.net

“Үндэсний хөтөлбөр, Үндэсний зөвлөлийг батлах тухай” УИХ-ын тогтоолыг бүрэн эхээр нь монгол, англи хэлээр нийтэлсэн ба Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр нь 1. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үндэслэл 2. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилт, зарчим, хэрэгжүүлэх хугацаа, гарах үр дүн 3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа зэрэг бүлгүүдтэй.

005.**Л.Батжав, 2003. “Хээл хахуулийн гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн үндсэн шинж”**

Ном, 144 хуудас, монгол

Номыг хууль зүйн доктор, дэд хурандаа Л.Батжав бичиж, УИХ-ын Хууль зүйн Байнгын хорооны дарга Ц.Шаравдорж хянан тохиолдуулан хэвлүүлжээ.

Уг номноос хээл хахуулийн гэмт хэргийн үндсэн шинжийг хэрхэн судлаж тодорхойлсон болон одоогийн үйлчилж буй холбогдох хууль тогтоомжийг хэрхэн хэрэглэх талаар зохиогчийн зөвлөгөөг үзэж болно.

006.

Л.Батжав, 2003. “Криминологийн зарим асуудал”

Ном, 338 хуудас, монгол

Номыг хууль зүйн доктор, дэд хурандаа Л.Батжав бичиж, доктор Н.Баатаржав, профессор Д.Мөрөн нар хянан, “BOLC” ХХК ивээн тэтгэж, Монголын хуульч залуучуудын холбооноос эрхлэн Аригү Графикас ХХК-д хэвлүүлжээ.

Энэхүү номыг гэмт хэрэг, түүний дотор авилгалын хэргийн талаар судалгаа шинжилгээний ажил хийж байгаа их, дээд сургуулийн оюутан, багш нар, судлаачид, практик ажилтнууд ашиглаж болно.

007.

Л.Батжав, 2005. “Хээл хахуулийн гэмт хэргийн эсрэг явуулах тэмцлийн зарим асуудал”

Ном, 248 хуудас, монгол

Номыг хууль зүйн доктор, дэд хурандаа Л.Батжав бичиж, профессор С.Жанцан хянан 2005 онд “Өнгөт-Од” ХХК-д хэвлүүлжээ. Энэхүү ном нь нийтийн номын сангууд болон Зориг сангийн номын санд ашиглагдаж байна. Имэйл: zorigfoundation@hotmail.com

Зохиогч энэхүү бүтээлдээ төр, хууль цаазын түүхийн уламжлалтай холбогдох их хэмжээний судалгааны материал, шүүхийн болон хууль сахиулах байгууллагуудын хээл хахуулийн эсрэг үйл ажиллагаанд холбогдох материалууд, 300 орчим ном, гарын авлага, криминологийн болон социологийн судалгааны үр дүнг ашиглан хээл хахуультай тэмцэх өөрийн боловсруулсан иж бүрэн төлөвлөгөөний талаар өгүүлсэн ажээ.

008.

Нээлтэй Нийгэм Хүрээлэн, 2004. “Европын холбоонд элсэх үйл явцыг хянах нь: Европын холбоонд шинээр элсэн орсон Зүүн Европын гурван улсын авилгал ба авилгалтай тэмцэх бодлого”

Ном, 275 хуудас, монгол орчуулга

“Methodology for monitoring corruption and anti-corruption policies in EU candidates states” номыг Ш.Ганболд, Г.Наран нар монгол хэл дээр орчуулан, ННФ, НҮБХХ,

УИХ-тай хамтран хэрэгжүүлж буй “Ардчилсан засаглалын Парламентыг бэхжүүлэх” төслөөс хамтран хэвлүүлжээ. Вэбсайт: www.forum.mn, www.eumar.org

Монгол Улс НҮБ-ын “Авилгалын эсрэг конвенци”-д нэгдэн орсон, мөн “Авилгалын эсрэг хууль”-иа шинэчлэн найруулж батлах болон “Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-өө эрчимтэй хэрэгжүүлэхэд нь туслах, ЕХ-ны улсуудын авилгалын эсрэг бодлого, бүтэц зохион байгуулалтын талаарх туршлага, сургамжуудтай танилцуулах зорилгоор уг номыг монгол хэл дээр орчуулсан байна.

Энэхүү номонд ЕХ-ны авилгалтай тэмцэх бодлогын стандартууд болон түүнтэй нийцүүлэн авилгалын эсрэг бодлогоо боловсронгуй болгосон Зүүн Европын улсуудын талаар орсон. Түүнчлэн Латви, Литва, Эстони улсуудын дэлгэрэнгүй тайлан багтсан.

009.

НҮБ, 2005. “Авилгалын эсрэг НҮБ-ын конвенци, 2005”

Конвенци, 53 хуудас

“Монгол Улс ба Авилгалын эсрэг НҮБ-ын конвенци” сэдэвт семинарт зориулсан материалыг Зориг сангийн номын сан, Авилгалын эсрэг НҮБ-ын конвенцийг www.parl.gov.mn вэбсайтаас үзэж болно.

“Монгол Улс ба Авилгалын эсрэг НҮБ-ын конвенци” сэдэвт семинарт зориулан, НҮБХХ монгол хэл рүү 2005 онд орчуулсан ба уг албан бус орчуулга уг семинар дээр тараагджээ. Монгол Улсын Их Хурлаас “Авилгалын эсрэг НҮБ-ын конвенци”-д 2005 оны 10-р сард нэгдэн орох шийдвэр гаргасан.

Конвенцийн зорилго нь *а/Авилгалаас урьдчилан сэргийлж, тэмцэх явдлыг илүү шуурхай, цр бүтээлтэй болгох, сурталчлах, б/Авилгалаас урьдчилан сэргийлж, тэмцэх, ашиглагдсан хөрөнгийг гаргуулах талаархи олон улсын хамтын ажиллагаа, техникийн туслалцааг дэмжин сурталчлах, в/төрийн албыг шударга явуулах, төрийн өмчийг хууль бусаар ашиглахад шударга, хариуцлага тооцох, зүй ёсны удирдлага хэрэгжүүлэх зарчмыг нэвтрүүлэх явдлыг дэмжих зэргээр тодорхойлсон байна.*

010.

О.Баттулга, 1995. “Коррупцийн ойлголт, мөн чанар”

Эрдэм шинжилгээний нийтлэл, 7 хуудас, монгол

Улс төрийн боловсролын академийн (УТБА) онол арга зүйн “Шинэ толь” сэтгүүлд /4/1995 онд (хуудас 35-41) хэвлэгдсэн ба тус академийн номын сангаас үзэж болно. Имэйл: reacademy@mobi.net.mn

УТБА-ийн эрдэм шинжилгээний ажилтан энэхүү өгүүлэлдээ коррупцийн ойлголт,

мөн чанарыг илэрхийлэх ба коррупцийн сөрөг чиг үүргийн тухай, коррупцитэй тэмцэх, арилгах тухай энд өгүүлсэн байна.

011.

Удирдлагын Академи, 1999. “Монгол дахь авилгалын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурь”, социологийн судалгааны тайлан, 1999 оны VI, VII сар

УИХ-ын архив, Данс 5 ХН2, Тайлан, 128 хуудас, монгол, англи

Уг социологийн судалгааг 1999 оны 4-6-р сард явуулахаар УИХ-ын даргын №48 захирамжид заасан. Судалгааг тендерт шалгарсан Я.Шуурав ахлагчтай баг МННХ (Соросын сан)-гийн санхүүжилтээр явуулж, судалгаанд нийт 2000 гаруй хүн хамрагдсаны дотор 1508 хүнээс анкетаар, 306 хүнээс стандарт сурвалжлагаар, 200 гаруй хүнээс чөлөөт сурвалжлагын аргаар мэдээлэл авч тайлангаа монгол болон англи хэл дээр гаргасан юм. Вэбсайт: www.aom.urh.mn

Судалгааг 1. Манай оронд авилгал гарч байгаа шалтгааныг хэрхэн үнэлэх вэ? 2. Таны бодлоор аль нь авилгал вэ? 3. Дараах байгууллагуудад авилга ямар түвшинд байна гэж Та үздэг вэ? 4. Авилгал ямар түвшинд зонхилж байна вэ? 5. Хэрэв та авилгын хэрэг илрүүлэлт хангалтгүй гэж үзэж байгаа бол энэ нь ямар шалтгаантай вэ? 6. Авилгын эсрэг хуулийн хэрэгжилт ямар гэж та боддог вэ? 7. Таны бодлоор авилгад хэн буруутай вэ? 8. Таны бодлоор дараах байгууллагууд өнөөдөр авилгын эсрэг хэрхэн тэмцэл хийж байна вэ? 9. Авилгын эсрэг тэмцэх тусгай, бие даасан, хараат бус байгууллагын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурийг сонжвол гэх зэрэг анкетын ерөнхий асуулгаар явуулсан.


012.

“Монгол дахь авилгалын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурь” социологийн судалгааны тухай товч мэдээлэл. 1999.12.15-нд Монголын Хэвлэлийн Хүрээлэн (МХХ) дээр болсон хэвлэлийн бага хурал дээр тараагдсан мэдээлэл

Мэдээлэл, 3 хуудас, монгол

Ажлын хэсгийн ахлагч Г.Ганхуягийн хийсэн дээрх хэвлэлийн бага хуралд зориулан, хуулийн төсөл боловсруулах ба судалгаа хариуцсан Ажлын хэсгийн гишүүн Д.Ламжав 1999.12.08-нд урьдчилан боловсруулжээ. Имэйл: lamjav@yahoo.com

Уг мэдээлэлд судалгааны гол үзүүлэлтүүдээс гадна судалгаа явуулах шийдвэр, тендерт шалгарсан судалгааны баг болон тендерийн комиссийн бүрэлдэхүүн, судалгааны багт интернетээр зөвлөх гадаадын шинжээчид, авилгалын олон улсын индекс, бас иймэрхүү судалгааг цаашид явуулахад анхаарах зүйлийн талаар товч мэдээлсэн байна.



013.**Б.Наранбаатар, 2000. “Монгол дахь авилгал, түүнтэй тэмцэх арга зам”**

Эрдэм шинжилгээний өгцлэл, 11 хуудас, монгол

Цагдаагийн Академийн номын сангаас Б.Наранбаатарын эрдэм шинжилгээний өгүүлэлийг үзэж болно.

Монгол дахь авилгалын өнөөгийн нөхцөл байдлыг улс төрийн, эдийн засгийн хүрээнд болон хууль хяналтын байгууллагын түвшинд авч үзсэн. Авилгал үүсэх болсон шалтгаан нөхцөлийг хүрээ тус бүр дээр бодит жишээнд тулгуурлан харуулжээ. Түүнчлэн авилгалын эсрэг тэмцэх арга замуудыг санал болгосон байна.

014.**С.Болдбаатар, 2000. “Албан тушаал, хээл хахуулийн гэмт хэргийн байдал, цаашид анхаарах асуудал”**

Эрдэм шинжилгээний илтгэл: 5 хуудас, монгол

Цагдаагийн академиас зохион байгуулсан “Шинэ төрлийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх асуудал” сэдэвт онол практикийн бага хуралд хэлэлцсэн илтгэлүүдийн эмхэтгэл. Бага хуралд хууль сахиулах байгууллагуудын удирдлага, эрдэмтэд, мэргэжлийн ажилтнууд оролцож Улсын мөрдөн байцаах газрын V хэлтсийн дарга С.Болдбаатар илтгэл тавьсан. Цагдаагийн академийн хэвлэх цехэд хэвлэсэн энэхүү эмхэтгэлийг тус академийн номын сангаас 371.30281, Ш-66 кодоор авч үзэж болно.

Эрдэм шинжилгээний илтгэлдээ: “... авилгал, хээл хахуулийн асуудал өнөөдөр манай улсын эдийн засгийн аюулгүй байдал, цаашид төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагаанд саад учруулах хэмжээнд хүрээд байна гэвэл маргах хүн гарахгүй байх. Манай улсын эдийн засгийн дорой байдал, төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаа муу зэрэг нь авилгал, хээл хахуулийн хэрэг гарах үндсэн шалтгаан юм. Албан тушаал хээл хахуулийн хэргийн бодит байдал, түүнийг илрүүлж шалгаж байгаа хэмжээ, хэргийг илрүүлж эцэслэн шийдэж байгааг харахад их зөрцөг гардаг. Албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар цаашид дараах асуудалд анхаарах хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд: Эрх зүйн орчин бүрдүүлэх, Төрийн албан хаагч нарын ёс зүйн хэм хэмжээг нарийн тогтоож, ажил цүргийн хуваарь, эрх цүргийг тодорхой болгох, Төрийн байгууллага, төрийн албан хаагч нарын үйл ажиллагаанд иргэдээс хяналт тавьдаг үнэлэлт, дүгнэлт өгдөг механизмыг боловсронгуй ил тод болгох зэрэг байна” гэжээ.

015.

J.Oyuntuya (National Project Coordinator), National Integrity Systems Country Study Report, Mongolia 2001,

Ж.Оюунтуяа (Төслийн Үндэсний зохицуулагч), Үндэсний Шударга Ёсны систем, судалгааны тайлан, 2001

Судалгааны тайлан, 24 хуудас, англи

Ардчилсан Засаглалыг Бэхжүүлэх Төслийн (Democratic Governing Institutions Capacity Building project) Үндэсний зохицуулагч Ж.Оюунтуяа энэхүү судалгааны тайланг хийж гүйцэтгэсэн байна. Вэбсайт: www.transparency.org/activities/nat_integ_systems/dnld/mongolia.pdf

Уг тайлан нь үндэсний шударга ёсны системийг бий болгоход нөлөөлөх хүчин зүйлүүдийг авч үзсэн ба мөн уг системийг бүрдүүлэгч хүчин буюу байгууллагуудад нүүрлээд байгаа авилгалын асуудлыг тус тусад нь авч үзсэнээрээ онцлог бөгөөд илүү цогц болжээ. Жишээ нь: гүйцэтгэх засаглал, хууль тогтоох байгууллага, улс төрийн намууд, улсын хянан шалгах хороо, шүүх цагдаа, төрийн алба, хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм, орон нутгийн засаг захиргаа гэх мэт уг байгууллагууд орж байна. Мөн эцэст нь эдгээр байгууллагуудад нүүрлээд буй авилгалтай хэрхэн тэмцэх талаархи зөвлөмжүүдийг санал болгожээ.

016.

В.Алтантүлхүүр, 2002. “Монголд авилгал хар тахал болтлоо хүчирхэгжсэний шалтгаан, түүний хор уршиг”

Эрдэм шинжилгээний илтгэл: 5 хуудас, монгол

Цагдаагийн Академийн эрхлэн хэвлүүлдэг “Багш, сонсогч оюутны эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл”-д 4в курсын сонсогч В.Алтантүлхүүрийн эрдэм шинжилгээний илтгэл нийтлэгдсэн. Цагдаагийн Академийн хэвлэх цехэд хэвлэсэн “Онол практикийн бага хурлын илтгэлүүдийн эмхэтгэл”-ийг тус академийн номын сангаас 371.30281. Б-14 кодоор авч үзэж болно.

Эрдэм шинжилгээний илтгэлдээ “1990 оны ардчилсан хувьсгалаар төрийн удирдах албан тушаалтнууд хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийгмийн гишүүд өрсөлдөөнд нэг гараанаас өрсөлдөж эхлэх орчин бүрдлээ гэж нийтэлж байсан. Энэ нь үнэн хэрэг дээрээ авилгал хэмээх далдын хүч нийгмийн гишүүдийн дунд ил гарч байсныг тухайн үед бид мэдэлгүй өнгөрөөжээ. Харин өнөөдөр хар тахал болтлоо хүчирхэгжсэнийг амьдрал харуулж байна.”

017.**Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ), 2002.
“Улс төрийн хүрээний авилгалын индекс, 2002 он”**

Судалгааны тайлан: 28 хуудас, монгол

Авилгалын эсрэг авч хэрэгжүүлж буй цогц арга хэмжээний нэг хэсэг болох энэхүү судалгааг www.anticorruption.mn вэбсайтаас үзэж болно.

Энэхүү судалгаа нь Монголд энэ чиглэлээр хийгдсэн анхны судалгаа юм. Судалгаа нь төр засгийн эрх баригч субъектуудийн авилгалын эсрэг авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болон авилгалд автагдсан байдлыг олон түмэн хэрхэн үнэлдэгийг харуулсан билээ.

018.**Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МХАҮТ), 2002. “Авилгалын индекс, 2002 он”**

Судалгааны тайлан: 44 хуудас, монгол

Авилгалын эсрэг авч хэрэгжүүлж буй цогц арга хэмжээний нэг хэсэг болох энэхүү судалгааг МННХ “Соросын сан”-гийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн ба www.anticorruption.mn вэбсайтаас үзэж болно.

Энэхүү судалгааны хүрээнд авилгалын өнөөгийн байдлыг тодорхойлон, авилгалын талаархи олон нийтийн ойлголтыг судалж, төр захиргааны байгууллагууд болон ТББ-уудын авилгалын эсрэг үйл ажиллагааг олон нийт хэрхэн үнэлж байгааг гаргаж ирсэн.

019.**Б.Алтансүх, 2003. “Авилгалын мөн чанар, түүний үр дагаврын асуудал”**

Эрдэм шинжилгээний нийтлэл, 9 хуудас, монгол

УТБА-ийн онол арга зүйн “Шинэ толь” сэтгүүлд 43/2003 (хуудас 59-67) хэвлэгдсэн бөгөөд тус академийн номын сангаас авч үзэж болно. Имэйл: reacademy@mobinet.mn

УТБА-ийн багшийн бичсэн нийтлэл нь авилгалын мөн чанар, өнөөгийн Монгол ба авилгал, авилгал ба улс төр гэсэн гурван дэд гарчигтай. Нийтлэлдээ авилгалтай амжилттай тэмцэхийн тулд түүний үүсгэж буй орчин, ямар үзэгдэл, үйл ажиллагааг багтааж байгааг авч үзэх шаардлагатайг дурдаад гол эх үүсвэрүүдийг 8 бүлэгт хуваан нэрлэсэн байна.

020.

Р.Ганболд, 2004. “Авилгалтай тэмцэх эрүүгийн эрх зүйн асуудал”

Магистрийн ажил: 57 хуудас, монгол, хураангуйг англи хэлээр

Удирдлагын Академийн номын сан, вэбсайт: www.aom.urh.mn

Авилгалын тухай ойлголт, мөн чанар, төрөл хэлбэр, хор холбогдлыг эрх зүйн талаас нь судалж түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эрүүгийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход хувь нэмэр оруулах бүтээл юм. Судалгааны төгсгөлд авилгалтай холбоотой гэмт хэргүүдийг нарийвчлан тодорхойлох, авилгалын гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын үр нөлөөг оновчтой болгох зэрэг авилгалтай тэмцэх эрүүгийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудлын талаар тодорхой саналууд боловсруулан дэвшүүлсэн байна.

021.


Transparency International, 2004. “Global Corruption Report 2004: Political corruption”

Транспэренси Интернэйшнл (ТИ), 2004. “Дэлхийн Авилгалын Тайлан 2004: Улс төрийн авилгал”

Тайлан, 353 хуудас, англи

ТИ байгууллагаас жил бүр эрхлэн гаргадаг энэхүү тайлангийн 2004 оны дугаарт Японы Мицуй компаны ажилтнууд 2001 оны 6-р сараас 2002 оны 4-р сарын хугацаанд Монголын Дэд Бүтцийн яамны өндөр албан тушаалтанд 1.3 сая иен буюу 11,000 ам.доллар өгсөн тухай хэргийн талаар багтаажээ. Энэ тухай номын 200-р хуудсаас уншиж болно. ТИ-ийн вэбсайт: www.transparency.org

Энэхүү номноос 2002 оны 6-р сараас 2003 оны 7-р сарын хооронд дэлхийн улс орнууд үндэсний болон олон улсын санаачлагууд, системийн болоод эрх зүйн өөрчлөлтүүд, түүнчлэн авилгалын эсрэг хувийн сектор болон иргэний нийгмийн хийсэн үйл ажиллагааг ерөнхийд нь мэдэж болох юм. 2004 оны тайланд улс төрийн авилгалын асуудлыг онцгойлон авч үзсэн байна. Номонд нийт 34 орны тайлан болон сүүлийн үеийн авилгалын эсрэг судалгаанууд багтжээ.



022.

ADB/OECD Anti-Corruption Initiative for Asia and the Pacific Secretariat, 2004. Anti-Corruption Policies in Asia and the Pacific: Self-Assessment Report Mongolia Jan.2004

АХБ/ЭЗХАХБ Ази, Номхон Далайн орнуудын Авилгалтай тэмцэх санаачлага, 2004. Ази, Номхон Далайн орнуудын Авилгалын эсрэг бодлого: Монгол Улсын авилгалын өөрийн үнэлгээ 2004 оны 1-р сар

Тайлан: 80 хуудас, англи

Үнэлгээг ХЗДХ-ийн дэд сайд Ц.Мөнх-Оргил болон тус яамны ажилтан Ш.Үнэнтөгс нар Ази, Номхон Далайн орнуудын Авилгалтай тэмцэх санаачлагаас гаргасан асуулгын дагуу боловсруулсан бөгөөд электрон хувилбарыг www1.oecd.org/daf/asiacom/stocktaking.htm хаягаар үзэж болно.

Уг үнэлгээ нь Монгол дахь авилгалын эсрэг авч явуулж буй бодлогыг 2004 оны 1 дүгээр сарын байдлаар авч үзсэн ба Ази, Номхон Далайн орнуудад авч явуулах авилгалын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийгджээ. Холбогдох хууль эрх зүйн орчин болон хэрэгжүүлэгч байгууллагын бүтэц, хийхээр төлөвлөж буй шинэчлэлийн талаар дурьджээ.

023.

Хүний Эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК), 2002. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл, 2002 он”

Илтгэл, 102 хуудас, монгол

Уг номыг Монголын ХЭҮК бэлтгэн, НҮБХХ, Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар (ХЭДКГ)-ын хамтарсан МОН/01/103 төслийн хүрээнд, 2003 онд “Хаан Принтинг” ХХК-д хэвлүүлжээ. Утас: 262902, 262971, Имэйл: contact@nhrc-mn.org, вэбсайт: www.nhrc-mn.org

НҮБ-ын санхүүжилтээр хийгдсэн “Хүний эрхийн үндэсний хөтөлбөр боловсруулах” төслийн хүрээнд 2001 оны 5-8-р сард “Хүний эрхийн төлөв байдал”-ын судалгаа нь уг илтгэлийн суурь болсон ажээ. Энэхүү судалгааг нийслэл болон бүх аймагт, 127 сум, 8822 өрх, 579 аж ахуйн нэгж байгууллага, 60 шахам мянган иргэдийг хамруулан хийжээ. Уг судалгааны дүнг 2001 онд олон улсын хүний эрхийн өдрөөр олон нийтэд зориулан хэвлүүлэн тараажээ.

Авилгал нь хүний эрхийн асуудлуудтай зайлшгүй холбогдож байдаг учраас Монгол улсын хэмжээнд хүний эрхийн асуудал ямар түвшинд байгааг мэдэхэд энэхүү бүтээл чухал үүрэгтэй.

024.

Хүний Эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК), 2003. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл, 2003”

National Human Rights Commission of Mongolia, 2003. “Human Rights and Freedoms in Mongolia, Status Report 2003”

Илтгэл, 124 хуудас, монгол, англи

Уг номыг Монголын ХЭҮК бэлтгэн, НҮБХХ/ХЭДКГ-ын хамтарсан МОН/01/103 төслийн хүрээнд, 2003 онд “Хаан Принтинг” ХХК-д хэвлүүлжээ. Утас: 262902, 262971, Имэйл: contact@nhrc-mn.org, вэбсайт: www.nhrc-mn.org

Уг номонд ХЭҮК-оос УИХ-д оруулсан хоёрдох илтгэлийг нийтэлснээс гадна Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн хоёрдугаар бүлэг, ХЭҮК-ын тухай Монгол Улсын хууль, тус комиссын Стратеги төлөвлөгөө болон УИХ-д оруулсан анхны буюу 2002 оны тайланг хавсаргасан байна. Үндсэн илтгэл нь 1. Нийгмийн эмзэг бүлгийн эрхийн төлөв байдал, 2. Зарим эрхийн хэрэгжилтийн байдал, 3. Хүний эрхийн анхаарал татаж буй өнөөгийн зарим асуудал, 4. Дүгнэлт, санал, зөвлөмж хэмээх дөрвөн бүлэгтэй юм. Уг илтгэлийг бэлтгэхдээ ХЭҮК явуулсан үйл ажиллагааныхаа явцад олж авсан мэдээлэл, хийсэн ажиглалт, судалгаа, иргэдийн өргөдөл гомдлын мөрөөр хийсэн хяналт шалгалтаар тогтоогдсон зөрчлийг авч үзэхийн зэрэгцээ төрийн болон ТББ-аас гаргасан илтгэл тайлан, олон улсын болон бүс нутгийн Хүний Эрхийн байгууллагуудын зөвлөмж, дүгнэлтүүдийг анхааран үзсэн ажээ.

Авилгал нь хүний эрхийн асуудлуудтай зайлшгүй холбогдож байдаг учраас Монгол улсын хэмжээнд хүний эрхийн асуудал ямар түвшинд байгааг мэдэхэд энэхүү бүтээл чухал үүрэгтэй.

025.


Хүний Эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК), 2004. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл 2004”

National Human Rights Commission of Mongolia, 2004. “Human Rights and Freedoms in Mongolia, Status Report 2004”

Илтгэл, 110 хуудас, монгол, англи

Уг илтгэлийг ХЭҮК бэлтгэн 2004 онд хэвлүүлжээ. Энэ нь ХЭҮК-ын тухай хуулийн 20.1-д заасны дагуу гаргасан гурав дахь илтгэл нь юм. ХЭҮК-ын Утас: 262902, 262971, Имэйл: contact@nhrc-mn.org, вэбсайт: www.nhrc-mn.org

Илтгэл дараах 4 бүлгээс тогтжээ: 1. Тодорхой эрхүүдийн хэрэгжилтийн төлөв байдал, 2. Эмзэг бүлгийн эрхийн асуудал, 3. Хүний эрхийн анхаарал татаж буй зарим асуудал, 4. Санал, Зөвлөмж.



1-р бүлэгт тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөө; Газар эзэмших, өмчлөх эрх; Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалын тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх; Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилт; Уул уурхайн салбарт ажиллагсдын эрхийн төлөв байдалд хийсэн хууль, эрх зүйн шинжилгээг ,

2-р бүлэгт Үндэсний цөөнхийн эрх; эмзэг бүлгийн иргэдийн нийгмийн хамгаалал, тусламж авах эрхийн төлөв байдалд хийсэн судалгааны дүнг,

3-р бүлэгт “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг” НҮБ-ын конвенци; хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын хэрэгжилт анхаарал татаж байгаа талаар баримт түшин өгүүлсэн байна.

Авилгал нь хүний эрхийн асуудлуудтай зайлшгүй холбогдож байдаг учраас Монгол улсын хэмжээнд хүний эрхийн асуудал ямар түвшинд байгааг мэдэхэд энэхүү бүтээл чухал үүрэгтэй.

026.


Хүний Эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК), 2005. “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл 2005”

National Human Rights Commission of Mongolia, 2005. “Human Rights and Freedoms in Mongolia, Status Report 2005”

Илтгэл, 106 хуудас, монгол, англи

Уг номыг Монголын ХЭҮК бэлтгэн 2005 онд “Хаан Принтинг” ХХК-д хэвлүүлжээ. Утас: 262902, 262971, Имэйл: contact@nhrc-mn.org, вэбсайт: www.nhrc-mn.org

Уг номонд ХЭҮК-ын 2005 оны ээлжит илтгэл, мөн тус комиссын үйл ажиллагаатай холбоотой зарим баримт бичгийг нийтэлжээ. Илтгэлд 2004 онд болж өнгөрсөн УИХ-ын болон Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын сонгуулиудтай холбогдуулан хүний сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн төлөв байдлыг авч үзсэн байна.



027.

**International Republican Institute (IRI), USAID, “Alternative Center”, 2004.
“Mongolia Nationwide Voter Survey, April 2004”.**

**Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн, АНУ-ын Олон Улсын
Хөгжлийн Агентлаг, “Альтернатив” төв, 2004 оны 4-р сар. “Монголын
сонгогчдын санаа бодлын судалгаа”**

Судалгаа, 79 хуудас, англи

Улаанбаатар дахь БНОУХ-гээс судалгааны тайланг авч болно. Хаяг: Жамъян гүнийн гудамж 9, өрөө 301. Вэбсайт: www.iri.org

Энэхүү судалгааг Альтернатив төвийн тэргүүн, МУИС-ын Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, доктор профессор Ц. Ганболд удирдан, Улс төр судлалын салбарын оюутан, магистрант, докторантууд хийжээ.

Уг судалгааг 2004 оны УИХ-ын сонгуулийн өмнө буюу 4-р сард орон даяар нийт 1800 хүний дунд явуулсан бөгөөд судалгаандаа улс төрийн намууд, улс төрчдийн рейтинг болон тэр үеийн амьжиргааны түвшин, улс орны эдийн засгийн байдал болон тулгамдаад буй асуудал, ирээдүйд ямар үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх талаархи санал гэх мэт олон асуудлыг хамруулсан.

Үүний дотор авилгалтай хэрхэн тэмцвэл үр дүнд хүрэх талаархи сонгогчдын саналыг оруулжээ. Мөн тэр үеийн Эх Орон Ардчилал эвслийн нэг амлалт болох авилгалтай тэмцэх уриа ард нийтэд хэр хүрсэн талаар судалгаанд тусгагджээ.

028.

**International Republican Institute (IRI), USAID, “Alternative Center”, 2005.
“Mongolia Nationwide Voter Survey, January 2005”.**

**Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн, АНУ-ын Олон Улсын
Хөгжлийн Агентлаг, “Альтернатив” төв, 2005 оны 1-р сар. “Монголын
сонгогчдын санаа бодлын судалгаа”**

Судалгаа, 51 хуудас, англи

Улаанбаатар дахь БНОУХ-гээс судалгааны тайланг авч болно. Хаяг: Жамъян гүнийн гудамж 9, өрөө 301. Вэбсайт: www.iri.org

Энэхүү судалгааг Альтернатив төвийн тэргүүн, МУИС-ын Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, доктор профессор Ц. Ганболд удирдан, Улс төр судлалын салбарын оюутан, магистрант, докторантууд хийжээ.

Уг судалгаа нь 2005 оны 5 сарын Ерөнхийлөгчийн сонгуулийг урьдчилан тандсанаараа онцлог бөгөөд Монголын өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага,

Засгийн газар ямар бодлогуудыг авч хэрэгжүүлвэл илүү ашигтай талаарх ард иргэдийн саналыг тусгажээ.

Мөн авилгалтай тэмцэхийн тулд ямар алхмуудыг хийх ёстой талаар иргэдээс санал авчээ. Энэ судалгааг эрдэмтэн судлаачид эрдмийн ажилдаа, бодлого боловсруулагчид бодлого боловсруулахдаа, олон улсын байгууллагууд цаашид ямар чиглэл, хүрээнд тусламж үзүүлж зөвлөгөө өгч болох талаар санаа авч болно.

029.

**International Republican Institute (IRI), USAID, “Alternative Center”, 2005.
“Mongolia Nationwide Voter Survey, May 2005”.**

**Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн, АНУ-ын Олон Улсын
Хөгжлийн Агентлаг, “Альтернатив” төв, 2005 оны 5-р сар. “Монголын
сонгогчдын санаа бодлын судалгаа”**

Судалгаа, 42 хуудас, англи

Улаанбаатар дахь БНОУХ-гээс судалгааны тайланг авч болно. Хаяг: Жамъян гүнийн гудамж 9, өрөө 301. Вэбсайт: www.iri.org

Энэхүү судалгааг Альтернатив төвийн тэргүүн, МУИС-ын Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, доктор профессор Ц. Ганболд удирдан хийж, Улс төр судлалын салбарын оюутан, магистрант, докторантууд оролцжээ.

Уг судалгаа нь 2005 оны 5 сард Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн рейтингийг урьдчилан тандсанаараа онцлог бөгөөд Монголын өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага, Засгийн газар хамгийн түрүүнд авч хэрэгжүүлвэл зохих алхмуудын талаар ард иргэдээс санал авчээ.

Мөн авилгалтай тэмцэхийн тулд ямар алхмуудыг хийх ёстой талаар иргэдийн саналыг тусгажээ. Энэ судалгааг эрдэмтэн судлаачид эрдмийн ажилдаа, бодлого боловсруулагчид бодлого боловсруулахдаа, мөн олон улсын байгууллагууд цаашид ямар чиглэл, хүрээнд тусламж үзүүлж зөвлөгөө өгч болох талаар бодит санааг авах боломжтой.

030.

**USAID, 2005. Assessment of Corruption in Mongolia, Final Report
АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (ОУХА), 2005. “Монгол улс
дахь авилгалын байдалд хийсэн үнэлгээний эцсийн тайлан”**

Үнэлгээний тайлан, 46 хуудас, англи, 78 хуудас, монгол

АНУ-ын ОУХА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын санхүүжилтээр Casals & Associates, Inc. (C&A) байгууллагаас Вашингтон дахь ОУХА болон Азийн Сантай

хамтран 2005 оны 6, 7-р сард Монгол улс дахь авилгалын байдалд үнэлгээ хийж энэхүү тайланг гаргажээ.

www.usaid.gov/mn/library/documents/MongoliaCorruptionAssessmentFinalReport.pdf хаягаар англи тайланг, [www.usaid.gov/mn/library/documents/Mongolia Corruption Assessment FinalReport-Mongolian.pdf](http://www.usaid.gov/mn/library/documents/Mongolia%20Corruption%20Assessment%20FinalReport-Mongolian.pdf) хаягаар монгол тайланг тус тус үзэж болно.

Тайлангийн гол дүгнэлт нь өмнө нь хийгдэж байсан судалгааны нэгэн адил Монгол улсад “жигжиг сажиг” буюу захиргааны түвшинд ч, “их хэмжээний” буюу элит түвшинд ч авилгалын боломж улам өссөөр байна гэж үзсэн байна. Авилгал өсөн нэмэгдэж байгаа шалтгаануудыг тодорхойлон авилгалаас урьдчилан сэргийлэх чиглэлд хийсэн арга хэмжээнүүдийг багтаасан байна. Үнэлгээний төгсгөлд авилгалын эсрэг цаашид хийж болох үйл ажиллагааны стратегийн зөвлөмжүүдийг санал болгосон байна.

031.

Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газар, Удирдлагын академи, 2005. “Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын хандлага”

Эмхэтгэл, 109 хуудас, монгол

Энэхүү судалгааг Азийн хөгжлийн банк, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн бөгөөд Удирдлагын академийн Нийгмийн удирдлагын сургуулийн захирал доктор, профессор П.Увш, судлаач, социологич Р.Сэлэнгэ, Ц.Төрбилэг нар эмхэтгэжээ. Судалгааг Удирдлагын академийн номын сангаас авч үзэж болно.

Төрөөс иргэдэд үйлчлэх үйл ажиллагааны өнөөгийн байдал, хандлагыг шинжлэх ухааны үндэслэл бүхий судалгааны аргуудад тулгуурлан онол, арга зүйн зохих түвшинд судлах анхны оролдлого хийж, орон нутагт төрийн үйлчилгээ хэрхэн эзэндээ хүрч буйг тоймлон гаргаж, чиг хандлагыг илрүүлсэн нь энэхүү бүтээлд бүрэн тусаагүй ч цаашид төрийн үйлчилгээний бодлогыг тодорхойлоход ач холбогдолтой.

032.

Удирдлагын Академи, П.Эрдэнэтунгалаг, 2005. “Авилгалын өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ, дүгнэлт”

Магистрын ажил, 72 хуудас, монгол

П.Эрдэнэтунгалагийн магистрийн ажлыг Удирдлагын академийн номын сангаас авч үзэж болно.

Энэхүү судалгааны ажилдаа авилгал өнөө үед ямар хэмжээнд байгаа, авилгалын эсрэг бодлого болон авилгалын эсрэг хууль боловсруулах эрх зүйн болон сэтгэл зүйн орчин бий болгох тухай, мөн засгийн газар бусад байгууллагуудын авилгалын эсрэг үйл ажиллагааны орчин хийгээд хэм хэмжээ, стандартуудыг судлахыг зорьсон байна.

033.

Mr. Ts. Nyamdorj, Minister of Justice and Home Affairs of Mongolia, May 2003, 3RD Global Forum on Fighting Corruption & Safeguarding Integrity, Seoul
ХЗДХ-ийн сайд Ц.Нямдорж, Авилгалтай тэмцэх ба шударга ёсыг хамгаалах дэлхийн 3-р чуулган, 2003 оны 5 дугаар сар, Сөүл хот

Илтгэл: 8 хуудас англи

ХЗДХ-ийн сайдын тавьсан энэхүү илтгэлийг www.anticorruption.mn вэбсайтаас үзэж болно.

Илтгэлд Монголд нүүрлээд байгаа авилгалын талаар дурьдсан бөгөөд урьд өмнө болон одоогийн нөхцөлд авилгалтай тэмцэхэд хуулийн болон ажлын хүрээнд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байсан, мөн хэрэгжүүлж байгаа талаар дурьджээ. Мөн цаашид хууль эрх зүйн хүрээнд юу хийх ёстой талаар дурьдаж, авилгал үүсгэдэг орчны талаар дурджээ. Илтгэлээс Монголд авилгалтай тэмцэхэд төрөөс ямар үйл ажиллагаа явуулж байгаа талаар товч мэдээлэл авч болно.

034.

Авилгалын эсрэг хуулийн төслүүд

Архивын материал, 153 хуудас, монгол, англи

УИХ-ын архив, Д№5, ХН№6, эхэлсэн 1996.4.5, дууссан 2001.1.24. Энд 2001.1.24-өөс хойш боловсруулагдсан хуулийн төслүүд ороогүй.

Авилгалын эсрэг хуулийн төсөл шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдсанаас хойш хуулийн төсөлд гаргаж байсан санаа, үзэл баримтлалуудыг дүгнэж, эрдэм шинжилгээ, судалгааны ажилдаа ашиглах боломжтой.

035.

УИХ, 1996. Авилгалын эсрэг Монгол Улсын хууль

Хууль, 6 хуудас, монгол

Уг хууль анх 1996.4.5-нд батлагджээ. www.parl.gov.mn вэбсайтаас үзэж болно. Уг хуулийг олох код: 96-Н-03.

Авилгалын эсрэг хуулийн зорилт нь авилгалаас урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах, гэм буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлохтой холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино. Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл, Хоёрдугаар бүлэг: Авилгалаас урьдчилан сэргийлэх, Гуравдугаар бүлэг: Авилгалын эсрэг хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага гэсэн бүлгүүдээс бүрдэнэ.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

036.

**УИХ, 2002. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр. УИХ-ын 2002.07.04
№41 тогтоол**

Тогтоол, 11 хуудас, монгол

Дээрх тогтоолын 1-р хавсралтаар уг хөтөлбөрийг, 2-р хавсралтаар “Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг албан тушаалын байдлаар нь томилсон байна. Эдгээр баримт бичгийг www.parl.gov.mn вэбсайтаас үзэж болно.

Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр нь 1. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн үндэслэл 2. Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилт, зарчим, хэрэгжүүлэх хугацаа, гарах үр дүн 3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа зэрэг бүлгүүдтэй.

037.

**УИХ, 1999. “Ажлын хэсэг байгуулах тухай УИХ-ын даргын 1999.4.14
№48 захирамж”**

Захирамж, 5 хуудас, монгол

Энэхүү захирамжаар Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах ажлын хэсгийг УИХ-ын гишүүн Г.Ганхуягаар ахлуулан 14 хүний бүрэлдэхүүнтэй; хуулийн төсөл боловсруулах 1-р хэсгийг УИХ-ын гишүүн С.Төмөрөөр ахлуулан 10 хүний бүрэлдэхүүнтэй; Үндэсний хөтөлбөр боловсруулах 2-р хэсгийг Хууль зүйн сайд Л.Цогоор ахлуулан 8 хүний бүрэлдэхүүнтэй; Санал асуулга, мэдээлэл, сургалт, судалгааны 3-р хэсгийг УИХ-ын гишүүн О.Энхтуяагаар ахлуулан 32 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан юм. Захирамжид зохион байгуулах ажлыг 11 үе шаттай төлөвлөсний дотор Авилгалтай тэмцэх бие даасан байгууллагын тухай хуулийг 1999 оны 5, 6-р сард УИХ-аар батлуулахаар заасан байна.

038.

**УИХ-ын Архив, 1999. “Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл”. УИХ-ын
архив, Д№5 ХН№1, эхэлсэн 1999.4.14, дууссан 1999.12.2;**

Архивын хавтаст материал, 242 хуудас, монгол

УИХ-ын Архивын энэхүү хавтаст материал дотор УИХ-ын даргын 1999.4.14№48 захирамжаар байгуулагдсан “Ажлын хэсэг”-т холбогдох материалуудыг хадгалжээ.

Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах ажлын хэсгийн баримтууд багтсан. Үүнд 1. Ажлын хэсэг байгуулах тухай, 2. Ажлын хэсгийн гишүүдийн утасны дугаар, 3. Ажлын хэсгийн гишүүдийн

хуралдааны ирц, 4. Ажлын хэсгийн хуралдааны товч мэдээлэл, 5. Ажлын хэсгийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл.

039.

“Авилгалын эсрэг хуулийн (2000.01.05-ны) төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал”

Санал, 4 хуудас, монгол

УИХ-ын даргын 1999.04.14 №48 захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг боловсруулсан хуулийн уг төслийг УИХ-ын нэр бүхий гишүүд хууль санаачилсан байлаа. Нэмэлт, өөрчлөлтийн саналыг Д.Ламжав томьёолон бичсэн болно. lamjav@yahoo.com

Уг хуулийн төсөл дээр шинжээч Спивелльтэй хамтран ажиллаж санал солилцсоны дараа энэхүү нэмэлт, өөрчлөлтийг оруулах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн юм. Авилгалын эсрэг хуулийг 1999 оны зун шинэчлэн найруулж батлахаар анх төлөвлөсөн боловч өнөөг хүртэл батлагдаагүй байна.

040.

УИХ-ын Архив, 2000. “Авилгалын эсрэг тэмцэх Монгол Улсын үндэсний төлөвлөгөөний баримт бичиг”. УИХ-ын архив, Д№5 ХН№5, эхэлсэн 1998.6.29, дууссан 2000.1.22

Архивын хавтаст материал, 217 хуудас, монгол

УИХ-ын Архивын энэхүү хавтас дотор УИХ-ын даргын 1999.4.14 №48 захирамжаар байгуулагдсан “Ажлын хэсэг”-т холбогдох зарим материалуудыг хадгалжээ. Гадаадын шинжээчдийн англи дээрх тайлан албан бус монгол орчуулгын хамт хадгалагдсан байна.

Үүнд: 1. Авилгалын эсрэг тэмцэх Монгол улсын үндэсний төлөвлөгөө /доктор Жон Куагийн/, 2. National Anti-Corruption Plan for Mongolia /Jon S.T.Quan, Ph.D Professor of Political Science Department, National University of Singapore/, 3. Report, advice and recommendations of B.E.D.de Speville following his assesment visit to Mongolia 23-30 November 1998, 4. Авилгалын эсрэг тэмцэх Монгол улсын үндэсний төлөвлөгөө /Де.Спевиллийн айчлалын тайлан/, 5. Mongolian National Anti-Corruption Plan, Report of B.E.D.de Speville on his second visit to Mongolia, 15-25 January 1999, 6. New poll shows many leading exporters using bribes /Press Release/, 7. Монгол улсын авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр /Де.Спевиллийн айчлалын тайлан/ 8. The Mongolian National Anti-Corruption Plan, Report of B.E.D.de Speville on his third visit to Mongolia, 14-22 January 2000

041.

УИХ-ын архив 2000. “Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн баримт бичиг”. УИХ-ын архив, Д№5 ХН№4, эхэлсэн 1998.11.23, дууссан 2000.2.9

Архивын хавтаст материал, 123 хуудас, монгол

УИХ-ын Архивын энэхүү хавтас дотор УИХ-ын даргын 1999.4.14 №48 захирамжаар байгуулагдсан “Ажлын хэсэг”-т холбогдох зарим материалуудыг хадгалжээ. Гадаадын шинжээчдийн англи дээрх тайлан албан бус монгол орчуулгын хамт хадгалагдсан байна.

Үүнд: 1. Баримт бичгийн жагсаалт, 2. Авилгалын эсрэг тэмцэх үндэсний хөтөлбөр /1998.11.23-30-нд Монголд ажилласан шинжээч Спевилийн тайлан/, 3. “Авилгалын эсрэг тэмцэх үндэсний хөтөлбөр” сэдэвт уулзалт ярилцлагын хөтөлбөр /Нүхт, 1999.01.19/, түүний хавсралт зэрэг материалууд орсон.

042.

Дэвид Бийтхам, Кевин Бойел, 2005. “Ардчиллыг танилцуулахуй: 80 Асуулт, хариулт”

Ном, 136 хуудас, монгол орчуулга

“Introducing democracy: 80 questions and answers, David Beetham and Kevin Boyle” номыг анх 1995 онд Policy Press хэвлэлийн газар Blackwell Publishers компанитай хамтран хэвлэсэн. ЮНЕСКО-гийн захиалга болон санхүүжилтээр, зохиогчдыг мөн тус байгууллагаас томилох замаар уг ном бичигдэж 2002 онд дахин хэвлэгдсэн. Энэхүү бүтээлийг ЮНЕСКО-гоос ардчилал, хүний эрхийн боловсролын хөтөлбөрийнхөө нэг хэсэг болгон гаргасан байна. Уг номыг нэгэн зэрэг олон хэл рүү орчуулан гаргаж байна. Монгол хэл рүү Г.Батбаяр орчуулж, Ж.Энхсайхан хянасан ба CEDAW Watch Төвийн санаачлага, ЮНЕСКО-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр Policy Press хэвлэлийн газар хэвлэжээ. Имэйл: cedaw@magicnet.mn

Авилгал нь шударга ёсонд, даамжирвал ҮШЁТ-нд заналхийлдэг. Иймээс ардчиллын үнэт зүйлсийн талаар нийтийг соён гэгээрүүлэх нь авилгалын эсрэг чиглэсэн чухал үйл ажиллагаа юм. ҮШЁТ-ны суурь нь мэдээлэлтэй ард түмэн, ардчиллын үнэт зүйлс хоёр юм. Ардчилал гэж юу вэ? Бид яагаад түүнийг үнэт зүйлээ болгох ёстой вэ? гэдэг нь эдгээр 80 асуултын зөвхөн 2 нь. Ардчиллын тухай хамгийн тулгамдсан 80 асуултыг олж нэгтгэн, тэдгээрт тодорхой бөгөөд баттай хариулт өгөх зорилгоор уг ном бүтээгджээ.

043.

“Өнөөдөр” сонин, 2001. “Эрх баригчдын эрмэлзэл, олон нийтийн оролцоо л авилгалыг хязгаарлаж чадна”

Ярилцлага, 2001.11.01 №255, 1-3 дугаар нүцрт

“Өнөөдөр” сонин манай нийгэмд тулгараад байгаа олон асуудлыг хөндөж байгаагийн нэг нь авилгалын тухай сэдэв юм. Энэ удаад зарим хүмүүсийг редакци дээр урьж ярилцлага хийсэн бөгөөд энэхүү ярилцлагад УИХ-ын гишүүн С.Төмөр, С.Оюун, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Ц.Мөнх-Оргил, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч, академич С.Нарангэрэл нар оролцов.

“Авилга (коррупци), хахууль (взятка) хоёр өөр өөр зүйл цу, эсвэл хэмжээгээрээ ялгаатай юм уу?, Авилгын ямар хэлбэрүүд байдаг бол? Аль нь манайд илүү түгээмэл байна вэ?, Тендер, төсөл тойрч авилга бий болдог гэдэгтэй хэн ч маргахгүй байх. Тендер шалгаруулах, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааг явал шударга болгох вэ?, Бэлэг авилгын хэлбэр мөн үү? Төрийн томоохон албан тушаалтанд сайн үүлдрийн малаас өгсүцлээд машин хүртэл өгч байна шүү дээ?, Монголд авилга бий, түгээгээр ч барахгүй нэлээд газар авсан гэдэгтэй нийгмийн аль ч давхаргынхан санал нийлдэг. Тэгвэл авилга манайд ямар төвшинд байна гэж үзэж байна вэ?” гэх мэт олон асуултуудаар ярилцсан байна.

044.

“Өнөөдөр” сонин, 2003. Х.Доржпалам “Авилга авагчдын айх булчирхайг ажилладаг болгоё”

Өгцүлэл, 2003.03.19 №064, 13-р нүцрт

Авилгалын хэргийн илрүүлэлт болон хууль эрх зүйн орчин гэх мэт олон талт асуудлын талаар нийтлэлдээ өгүүлсэн байна.

“Манай улс дахь авилгын гэмт хэргийг илрүүлэн шийдвэрлэж байгаа үйл явцыг хөндлөнгөөс ажихад сүржин нь аргагүй шалгаж эхэлснээ сүцлээд бүр шалдаа бууж эрүү цүсгэсэн хэргээ хэрэгсэхгүй болгочихдог нь авлигад автагдсаных уу, аль эсвэл мэргэжлийн ур чадваргүйнх цү гэдэг нь ойлгогддоггүй.”

045.

“Зууны мэдээ” сонин, 2003. Н.Алтантуяа “Авилгал буух эзэнгүй “нисч” явна”

Өгцүлэл, 2003.03.31 №75, 2-р нүцрт

“Авилгалтай тэмцэх үндэсний бага хуралд тавьсан илтгэл, салбар хуралдаанаас

гарсан зөвлөмж, хүмүүсийн хэлсэн үгээс үзэхэд авилгал ямар шатанд, аль салбарт хэрхэн үүсч байгаа талаар а/эрх мэдэл ба авилгал б/хувийн хэвшил ба авилгал в/сонгууль ба авилгал г/авилгалыг хариуцлагатай сэтгүүл зүй илчилж чадна” гэсэн сэдвүүдээр илэрхийлсэн байна.

046.

“Үнэн” сонин, 2003. Т.Бүдээхүү “Авилгаар ажлаа бүтээе гэж байгаа бол гараа тат”

Өгцүлэл, 2003.04.01, №064, 1,5-р нүцрт

Сэтгүүлч: “... Авилга гэгч өөрөө далдын нууцлагдмал хар малгай дор оршин байдаг болохоор тийм учраас гэх тоймтой хариу алга. Үнэндээ авилга нь нийгмийн болон эдийн засаг, оюун санааны хэд хэдэн хүчин зүйлтэй холбоотой боловч авилгын талаархи нарийвчилсан дүн шинжилгээ өгөхцүй судалгаа дутагдаж байна” гээд а/авилгын талаархи нарийвчилсан судалгаа цгцйлэгдэж байна б/хариуцлагагүй цг яриа нийгмийг авилгад дасгаж байна в/төрийн албан хаагч хилэнц хурааж амьдрах хэрэг байна уу г/авилгын эсрэг тэмцэлд иргэд идэвхтэй оролцъё д/төр, авилга хоёрын алийг нь цлдээх вэ?” гэсэн сэдвүүдээр саналаа илэрхийлжээ.

047.

“Улаанбаатар таймс” сонин, 2003. Н.Энхлэн “Монголын нийгэмд тогтолцооны авилга нүүрлэсэн үү?”

Өгцүлэл, 2003.04.02 №68, 4-р нүцрт

Энэхүү өгүүлэлд: “...Манай нийгэмд авилга хаагуур “гцйгээд” байна вэ? Авилгыг хэн өгч хэн нь аваад хэрхэн шийтгэл хүлээсэн гэх тоо, баримт судалгаа алга. Төрийн бус байгууллагууд авилгалтай тэмцэж, судалж байгаа боловч тус тусдаа, хийсэн хэрэгжцүлсэн ажил нь тодорхой цр дүнд хүрэлгүй цаасан дээр бичигдээд өнгөрдөг аж. Сонгуульд нэр дэвшигчид, хууль хяналтын байгууллага, газрын албаныхан хэрхэн авилгалд автагтдаг” талаар баримтаар өгүүлсэн байна.

048.

“Өнөөдөр” сонин, 2003. Л.Батжав “Монголд хүнд суртлын Авлига ноёрхдог”

Ярилцлага, 2003.04.07 №82, 5-р нүцрт

Авилгатай нийтээрээ тэмцье “Өнөөдөр”-ийн сэдвийн ярилцлагад Хилийн цэргийн дээд сургуулийн хуулийн тэнхмийн эрхлэгч, дэд хурандаа, докторант Л.Батжавтай сэтгүүлч Д.Заябатын хийсэн ярилцлага.

“Манайд коррупцийг олон янзаар тайлбарладаг, хээл хахуулиар судалгаа хийж байгаа хүний хувьд коррупци гэсэн үгний утгыг тайлбарлаж өгнө үү?, Манай улсын эрцүгийн хуульд хээл хахуулийн гэмт хэрэгт ямар ял оноохоор заасан, энэ нь бусад улсын хуультай харьцуулбал хатуу, зөөлөн нь ямар вэ?, Өнөөдөр монголын нийгэмд яг ямар бодлого үгцйлэгдэж байна вэ? Таны хувьд ямар бодлого явуулаасай гэж бодож байна?” гэх мэт асуулгаар харилцан ярилцсан байна.

049.

“Үнэн” сонин, 2003. Ц.Шаравдорж /УИХ-ын гишүүн/ “Зөвхөн Африк болон Монголд л байдаг авилгын нэгэн хэлбэр”

Өгцүлэл, 2003.04.16 №07, 1,5-р нцүрт

“Дэлхийн зарим оронтой адил нийгэм нь бүхэлдээ авилгалд автсан, тцүнтэй тэмцэх аливаа оролдлого амжилтанд хүрэхгүй байгаагаас тцүний өмнө гараа өргөн бууж өгсөн байдалд Монгол улс орчихоогүй байна. Үүнд би итгэлтэй байгаа бөгөөд ингэж хэлэх бүрэн үндэслэл бий. Гэхдээ авилгын зарим хэлбэр тцүнийг цүсгэн бий болгогч, өдөөгч хүчин зүйлцүд байгааг хүлээн зөвшөөрөхгүй байж болохгүй юм. Эрцүл саруул ухаанд байх ёстой хэм хэмжээнээс хальсан утгагүй сэтгэхцүйд хөтлөгдсөн нутаг ус, танил тал гэдэг нэрийн дор бүлэглэж хууль, шударга ёс, нийтийн эрх ашигт саад болж байгаа цүлдэл, цүйл ажиллагааг авилгалын нэгэн хэлбэр” гэж үзсэн байна.

050.

“Үнэн” сонин, 2003. Ж.Ирээдүй “Авилга танд хоол болохгүй”

Өгцүлэл, 2003.06.18 №120, 2-р нцүрт

“Авилга нь ямар нэгэн давтагдашигүй хүчин зүйлийн нөлөөллөөр бус хүний ухамсартай цүйл ажиллагааны улмаас бий болж байгаа болохоор цр, үндсээр нь таслах боломжтой. Товчоор хэлэхэд авилга өгөхгүй, авахгүй байх хоёрхон цүйдлээс л хамаарах юм.

Олон жил далд яригдаж, тэр чинээгээрээ далд цүцүглэсэн авилгын буглааг ил гаргах, таслан зогсоох ажилд иргэн бүрийн оролцоо чухал гээд Авилга яагаад цүсдэг вэ? Цалин нь хүрэлцэхгүй нь гээд авилга авах ёстой юу?” гэсэн сэдвүүдээр санал бодлоо илэрхийлсэн.

051.**“Үнэн” сонин, 2004. Т.Бүдээхүү “Авилгалын эсрэг тэмцэлд хүч нэмэхүй”**

Өгцүлэл, 2004.02.13 №323, 3-р нүцрт

“Авилгал хээл хахуулийн хүрээ, тархалтын талаархи элдэв сүржин таамаглалд анх удаа зориглон сөрөг хариулт өгөхийн тулд дээрх асуултад хариулъя. Учир нь авилгал, хээл хахууль газар авснаар төр туйлдаж, цндэсний аюулгүй байдал ганхахад хүрнэ гэж эрдэмтэн, судлаачид томъёолдог бөгөөд авилга нийгмийг аймшигт аюулын эрмэг дээр авчирсан эсэхийг төрийн дүр төрхөөс ажиглаж болно гэсэн үг.” Туйлдсан төр үү?, Авилгалын эсрэг нэг алхам, Авилгалын эсрэг хоёр алхам, Авилгалын эсрэг гурав дахь алхам, Дараагийн алхам хүртэл бодит боломжоо ашиглая” гэсэн сэдвүүдээр санал бодлоо илэрхийлсэн.

052.**“Зууны мэдээ”, 2004. Д.Мөнхжаргал “Авилгалд автагдсан Монгол”**

Өгцүлэл, 2004.11.01 №258, 3-р нүцрт

Авилгалтай тэмцэхэд бие даасан хяналтын хороогоор хэрэгжүүлвэл илүү үр дүнд хүрэх боломжтойг бусад орны жишээн дээр харьцуулсан байна.

“Хүчний нийгмийн хөгжлийн аль ч шатанд авилгал, хээл хахууль гэгч сөрөг үзэгдэл амь бөхтэй оршсоор иржээ. Дэлхий нийт “corruption” гэж нэрлэдэг энэ ёс бус явдал Монгол оронд хэдийнээс цндэс хөрсөө суулгаж, соёолж эхэлсэн нь тодорхойгүй ч эдийн засагт хувийн хэвшлийн гүйцэтгэх цүрэг өсөн нэмэгдэж, төрийн оролцоо хэвээр хадгалагдсан сүцлийн арваад жил асар хурдацтай урган төлжиж, одоо нийгмийн хөгжил дэвшилд сөрөг нөлөө үзүцүлэхүйц хэмжээнд хүрсэн байна. Үүнийг дээр дооргүй мэддэг, мэдэрдэг ч хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм.”

053.**“Өдрийн сонин”, 2004. Жа.Пүрэв “Авилгалтай тэмцэх монгол ухаанаа сэтгэж олъё”**

Өгцүлэл, 2004.12.20 №312, 5-р нүцрт

“Авилгал гэгч Монголыг сөнөөх дайсан. Бид авилгалтай дайн зарласан боловч түүнтэй тэмцэх арга барил, зэвсэг, техникгүйн учир цр дүнг нь горьдолтгүй бололтой. Монгол авилгалын ганц хэрэг илрүцүлсэн. Тэр нь казиногийн гэх хэрэг. Үүнээс өөр олны нүд, чихэнд өртөхөөр хэрэг илэрснийг мэдсэнгүй. Ард түмний бухимдлын халуун цэг нь авилгал гэж санадаг. Авилгалтай тэмцэх арга ухаанаа бусад орноос хуулбарлахынхаа оронд өөрсдийн монгол ухаанаар авилгалтай тэмцэх арга замыг олж бусдад экспортлох хэрэгтэй” хэмээн онцолсон байна.

054.

“Өнөөдөр” сонин, 2005. Д.Дагва “Авилга устав уу, авдаг, өгдөг нь нарийсав уу?”
Өгцүлэл, 2005.01.08 №005, 3-р нүцрт

“Олон улсын зарим байгууллагаас гаргасан судалгаагаар манай орон авилгал, хээл хахуулийн хэмжээгээрээ нэлээд дээгцүрт ордог. Гэтэл сүүлийн хэдэн жилд авилгал, хээл хахуультай холбоотой нэг ч асуудал гарсангүй. Нийгмийг дотроос нь чимээгүйхэн идэж устгадаг энэ бусармаг үзэгдэл байхгүй болсон юм шиг л таг чиг. Авилга устав уу, авдаг, өгдөг нь нарийсав уу? гэтэл өнөөдөр манай нийгэмд бодитойгоор оршсоор байна” гэж баримтаар өгүүлсэн байна.

055.

“Монголын мэдээ” сонин, 2005. Б.Заяа “Авилгач “хорхойнууд”
Өгцүлэл, 2005.02.03 №023, 4-р нүцрт

“Авилгалд өртөөд байгаа учрыг хүмүүс мөнгийг хэт шүтэх болсноос, албан тушаалтнууд хариуцлага хүлээдэггүйгээс, хүмүүсийн амьжиргаа дорой болсноос, төрийн албан хаагчийн цалин бага, хүмүүсийн ёс суртахуун доройтож эх захаа алдсанаас болсон гэж ойлгодог.”

Авилгалыг “шимэгч хорхойтой” зүйрлэж, монголчууд нийтээрээ өвчлөх шинжтэй байгаа талаар нийтлэлдээ илэрхийлсэн байна.

056.

“Өдрийн сонин” сонин 2005. Д.Дамдинжав “Та авилга авдаг уу, өгдөг үү?”
Өгцүлэл, 2005.02.18 №044, 3-р нүцрт

“Хүмүүст хэтэрхий дасал болчихоод, аюул нь төдий л айдас төрцүлэхээ байсан зүйл бол авилга. Түүнийг удаан үйлчилдэг хортой адилтгаж болно. Үнэндээ ч авилга, хээл хахууль ил бус далд явагддагт түүний аюул бий. Хэн нэгэнд талархсан сэтгэлээ илэрхийлж, гарыг нь цайлгадаг уламжлалт сэтгэлгээ ийнхүү авилгалыг өөшицүлэх бэлээхэн хөрс болж байна” гэж нийтлэлдээ өгүүлжээ.

057.

“Монголын мэдээ” сонин, 2005. Ц.Цэрэн “Авилгалтай тэмцэх онцгой загвар”
Өгцүлэл, 2005.04.27 №83, 7-р нүцрт

Авилгалтай тэмцэх хууль, байгууллагагүй ч дэлхийд хамгийн бага авилгатай орон

болох Финланд улсын загварын тухай. Финланд улс нь авилга, хээл хахуулийн түвшингээр дэлхийд сүүлийн байр эзэлдэг бөгөөд амжилт, туршлагын талаар дэлгэрэнгүй өгүүлжээ.

058.

“Инфо” сонин, 2005. Ц.Оюунчимэг “Авилгалын үнэр”

Өгцүлэл, 2005.05.03 №17, 4-р нүцрт

“...Авилгал лав л та бидний нүдэнд огт харагдахгүй, тэр ч байтугай гарт баригдахгүй. Яг л хий үзэгдэл шиг зөвхөн сураг нь сонсогдох төдий байдаг эд. Гэтэл нүдэнд харагдахгүй атлаа чихэнд сонсогдоод байгаа зүйлтэй тэмцэнэ гээд байхаар хаана байгааг асуухаас өөр яах билээ. Авилгал нь нийгэмд ядуурал, ажилгүйдлийг чимээгүйхэн бий болгодог хий үзэгдэл” гэж тодорхойлсон байна.

059.

“Өнөөдөр” сонин, 2005. Э.Эрдэнэчимэг “Авилгалд гарц байна уу?”

Өгцүлэл, 2005.05.12 №112, 9-р нүцрт

Авилгалыг нийгэмд үзүүлэх нөлөөгөөр нь дараахь үндсэн гурван хэлбэрт авч үзсэн байна. Үүнд 1. Тохиолдлын хэлбэр 2. Зохион байгуулалтын хэлбэр 3. Хямралт хэлбэр. “... Энэ гурван хэлбэрийг Монголын орчинд шинжиж үзэхэд авилга зохион байгуулалтын хэлбэрээ нэгэнт олж цаашаа хямралт хэлбэр рүүгээ явж байна гэсэн дүгнэлтэд хүрсэн байна. Авилга хямралт байдалд хүрсэн тохиолдолд ганц хоёр хууль гаргаснаар, хэн нэгнийг илрүүлж шийтгэснээр, эсхүл авилгатай тэмцэх ямар нэг байгууллага бий болгосноор асуудлыг амжилттай шийдвэрлэж чаддаггүй. Харин амжилт авчрах хамгийн гол хүчин зүйл нь төрийн дээд удирдлагад авилгалтай тэмцэх үнэн сэтгэл, шахалт шаардлага хувь хүнийх нь хувьд бий болсон байх явдал юм” гэж үзсэн байна.

2

АВИАГАЛ БА
ЗАСАГЛААЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

060.

Ц.Самбаллхүндэв, Ж.Оюунтуяа, 2001. “Монгол Улсын Засгийн газрын “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр”-ийн бодлогын баримт бичиг”

Ном, 30 хуудас, монгол

Уг баримт бичгийг Ц.Самбаллхүндэв, Ж.Оюунтуяа нар эмхэтгэн, Засгийн газар 2001 онд хэвлүүлсэн байна.

Уг баримт бичигт Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх 11 чиглэлийг тодорхойлж, хөтөлбөрийн үндсэн зорилтыг хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг бүрээр томъёолсон байна. Уг хөтөлбөрийг Засгийн газрын 2000.10.18-ны өдрийн хуралдаанаар зарчмын хувьд зүйтэй гэж үзсэн байна.

“Монгол дахь хүний аюулгүй байдалд учирч буй аюул занал нь цогцолбор бөгөөд дээд зэргийн харилцан уялдаа холбоо бүхий цйл явцууд байдаг. Дээр дурьдсан цйл явцад цөлжилт, агаарын бохирдол, байгалийн гамшигт өртөмтгий байдал, эдийн засгийн уналт, хөрөнгө оруулалт, төслийн хэрэгжилтийн түвшин доогуур, орлогын хомсдол, ажилгүйдэл, ядуурал, эрцүл мэнд, боловсролын цйлчилгээний уналт, авилгал, гэмт хэрэг, улс төрийн тогтворгүй байдал, бодлогын залгамж чанар алдагдах болон технологи, эдийн засаг, соёлын глобальчлал хамаарна.”

061.

Монгол Улсын ЗГХЭГ-ын Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс; Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөрийг (ХАБХСЗХ) дэмжих төслийн удирдлагын нэгж, 2002. “Хяналт-шинжилгээ, үнэлгээ: Шалгуур үзүүлэлт, явц, үр дүн”

Ном, 81 хуудас, монгол

Уг номыг ЗГХЭГ-ын Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс; ХАБХСЗ хөтөлбөрийг дэмжих төслийн удирдлагын нэгж хариуцан, New Mind technology ХХК-д хэвлүүлжээ. Имэйл: gghspmu@mongol.net

Экспертийн хэсэг, ЗГХЭГ-ын болон яамдын холбогдох нэгжүүдийг оролцуулан Засгийн газраас эхлүүлсэн ХАБХСЗ хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилт түүний гарааны нөхцөл, хэрэгжилтэнд эхний нэг жил хагасын байдлаар мониторинг хийсэн байна. Номонд энэхүү завсрын мониторингийн дүн болон мониторинг хийсэн аргачиллыг багтаажээ.

“Засгийн газрын цйл ажиллагааны стратеги, бодлогын зорилт, хүлээгдэж буй үр дүн хэрхэн хангагдаж байгааг урьдчилан харж амжилтыг бататгах, хазайлт, гажуудлыг илрүцүлж засах, цйл ажиллагааг эрчимжүцүлэх, хамгийн оновчтой арга

хэлбэрийг эрэлхийлэх, цр ашиг, цр нөлөөг дээшлүүлэхэд хяналт шинжилгээ, үнэлгээний ажил чиглэгдэв.”

062.

В.Удвал, 2002. “Төрийн албаны талаарх хууль, эрх зүйн актын эмхэтгэл”

Ном, 248 хуудас, монгол

Уг эмхэтгэлийг Удирдлагын академийн Төрийн Удирдлагын Сургууль хариуцан, 2002 онд “Бит Сервис” ХХК-ий хэвлэх үйлдвэрт хэвлүүлжээ. Удирдлагын академийн номын сангаас авч үзэж болно.

Энэхүү эмхэтгэл нь эрдэмтэн судлаач, сонирхсон хэн боловч Авилгалын эсрэг хууль, эрх зүйн орчинг судалж үнэлэхэд эх сурвалж болох ба авилгалын эсрэг төрийн үйлчилгээний эрх зүйн зохицуулалт нь хэр зэрэг үр дүнтэй механизм болж байгааг судлахад нэгдсэн мэдээлэл болно.

063.

Зориг сан, 2002. “Сайн засаглал” олон улсын бага хурлын илтгэлүүд

Ном, 100 хуудас, монгол

Зориг сан, ААШДХ, БНОХ хамтран “Сайн засаглал” олон улсын бага хурлыг 2001 оны 2 сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан бөгөөд бага хуралд 14 орны төлөөлөгч, 21 аймгийн ЗДТГ-ын дарга, намуудын төлөөлөгч, олон улсын байгууллагууд болон хэвлэл мэдээллийнхэн зэрэг нийт 110 төлөөлөгч оролцсон ажээ. Бага хурал дээр тавигдсан илтгэлүүдийг Засгийн газрын ХАБХСЗ хөтөлбөрийг Дэмжих төслийн удирдлагын нэгжийн ивээл дор Зориг сан хариуцан 2002 онд хэвлүүлсэн байна. Энэхүү номыг Зориг сангийн номын сан болон www.zorigfoundation.org.mn вэбсайтаас үзэж болно.

Бага хурал нэг талаас Монголын Засгийн газраас гаргасан ХАБХСЗ хөтөлбөрийг дэмжих, нөгөө талаас төрийн үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байх зарчмыг дэлгэрүүлэхэд чиглэгдсэн байна. Бага хурлаар дараах сэдвүүдийг онцлон хэлэлцсэн байна: 1. Сайн засаглалын тухай, 2. Ил тод байдал, хариуцлагын тогтолцоо, 3. Авилгалтай тэмцэх нь, төрийн албан хаагчийн ёс зүй, 4. Сайн засаглалыг бүрдүүлэхэд иргэний нийгэм ба хувийн хэвшлийнхний үүрэг оролцоо.

064.

Марк Грамбергер, 2003. “Иргэн түншлэгч болох нь: Бодлого боловсруулах явцад мэдээлэх, зөвлөлдөх, олон нийтийг оролцуулах”

Ном, 112 хуудас, монгол, англи

(Citizens as Partners: Information, Consultation and Public Participation in Policy-making /Marc Gramberger, 2001) номыг анх ЭЗХАХБ (OECD)-ын захиалгаар бичжээ. Уг номыг тус байгууллагын зөвшөөрснөөр МННХ (Соросын сан) санаачлан монгол хэл дээр орчуулж хэвлүүлсэн байна. Зохиогчийн хаяг: marc@gramberber.com, орчуулга эрхэлсэн байгууллагын хаяг: osf@soros.org.mn, вэбсайт www.forum.mn.

ЭЗХАХБ-ын ууган гишүүд нь Австри, Бельги, Канад, Дани, Франц, Герман, Грек, Исланд, Ирланд, Итали, Люксембург, Нидерланд, Норвеги, Португали, Испани, Швед, Швейцари, Турк, Их Британийн Нэгдсэн Вант Улс, АНУ гэсэн 21 улс байдаг ба хожим Япон, Финлянд, Авсрали, Шинэ Зеланд, Мексик, Чех, Унгар, Польш, Солонгос, Словак гэсэн 10 улс гишүүнээр элсжээ. Уг ном нь ЭЗХАХБ-ын гишүүн буюу гишүүн бус улсуудын төрийн албан хаагчдад зориулсан, төрийн үйлчилгээний арга барилыг улам боловсронгуй болгоход чиглэсэн, үүнд мэдээлэл холбооны технологийн дэвшлийг хэрхэн ашиглах талаар зөвлөсөн практик удирдамжийн шинжтэй гарын авлага юм. Зохиогч ном нь монгол хэл дээр орчуулан хэвлэгдсэн даруй Монголд ирж семинар зохиож байлаа.

Шийдвэр гаргах үйл явцын бүх шатанд иргэд, сонирхлын бүлгүүдийн оролцоо хангах нь ил тод байдлыг бий болгон бодитой шийдвэр гаргахад нөлөөлж, улмаар авилгалын эсрэг чиглэсэн үйл ажиллагаа болдог.

065.

АШСТО-ын V бага хурлыг зохион байгуулах комисс, 2003 он “Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхэтгэл”

Ном, 359 хуудас, монгол орчуулга

Энэхүү номонд “Ардчилал, сайн засаглал, иргэний нийгэм” хэмээх ерөнхий сэдвийн доор явагдсан АШСТО-ын V бага хурлын (2003.9.10-12, Улаанбаатар) хэлэлцүүлэгт зориулан НҮБ-ын шугамаар энэ салбарын нэртэй судлаачдад захиалан бичүүлсэн 13 судалгааны ажил, 3 тойм өгүүлэл, мөн тус бага хурлын төгсгөлийн баримт бичиг болох “Улаанбаатарын Тунхаглал”, “Үйл ажиллагааны хөтөлбөр” хоёрыг орчуулан эмхэтгэж, “Урлах эрдэм” ХХК-д хэвлүүлжээ. Тус бага хурлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, уг эмхэтгэлд орсон материалуудыг англи, франц, испани, орос хэл дээр www.icnrd5-mongolia.mn вэбсайтаас үзэж болно.

Уг эмхэтгэлд “сайн засаглал”, “хуулийг дээдлэх ёс”, “хариуцлагын тогтолцоо”, “ядуурал” гэх мэт суурь ухагдахуунуудыг тодорхойлон тайлбарласнаас гадна удирдлагын

янз бүрийн түвшинд амжилтанд хүрсэн жишээнүүдийг оруулж, товч зөвлөмжүүдийг өгсөн байна.

066.

Ш.Батсүх, Б.Батхүү, С.Ганболд, Ц.Даваадорж, Ч.Тунгалаг, Д.Цолмон нар, 2003. “Засаглалын нэр томъёоны тайлбар”

Ном, 101 хуудас, монгол, англи

Уг тайлбарыг Монгол Улсын Засгийн газрын Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөрийн хүрээнд /Ш.Батсүх, Б.Батхүү, С.Ганболд, Ц.Даваадорж, Ч.Тунгалаг, Д.Цолмон нар/ боловсруулан хэвлүүлжээ.

Тайлбарыг боловсруулахдаа 1996 онд НҮБХХ, Удирдлагын хөгжлийн хөтөлбөрөөс гаргасан нэр томъёоны тайлбар толийг суурь болгон, төрийн захиргааны өөрчлөлтийг тодорхойлогч ойлголтуудыг монгол-англи хэл дээр дэлгэрүүлэн тусгасан ажээ.

067.

Ш.Батсүх, Б.Батхүү, С.Ганболд, Ц.Даваадорж, Ч.Тунгалаг, Д.Цолмон нарын судалгааны баг, 2003 .“Сайн засаглал” (Судалгааны тайлан)

Ном, 111 хуудас, монгол

Уг судалгааг дээрх судалгааны баг НҮБХХ, Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөрийг дэмжих төслийн нэгж, Засгийн газрын ХЭГ-ын захиалга дэмжлэгээр явуулсан байна. Судалгааны багтай холбогдох Имэйл: batsukh@aom.edu.mn бөгөөд Зориг сангийн номын сангаас авч үзэж болно.

Судалгааны баг дараах судалгааг явуулж дүн шинжилгээ хийсэн: засаглал, хүний аюулгүй байдлын чиглэлээр өмнө хийгдсэн судалгааны тайлангууд, хууль эрхийн актууд, хөтөлбөр ба төслийн баримт бичгүүдийг судлах; 276 хүнээс санал асуулга авах; сонирхогч талуудыг оролцуулан хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлага зохиох; тухайн сэдвээр өргөн хэрэглэгддэг нэр томъёог тайлбарлах.

Тус багийн явуулсан судалгаагаар төрийн албанд авилгал хамгийн их гэсэн үзүүлэлт гарсан бөгөөд монголд авилгалын торон сүлжээ үүссэн тухай тэмдэглэсэн байна.

068.

Дэвид Бийтхэм, Сара Брекин, Лейэн Кейртон, Стюарт Вейр, 2005. “Ардчилалд үнэлгээ өгөх гарын авлага”

Ном, 186 хуудас, монгол орчуулга

Энэхүү гарын авлагыг АСТОУХ (IDEA) эрхлэн хэвлүүлжээ. Гарын авлагыг

АШСТО-ын V бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх НҮБХХ төслөөс монгол хэл рүү орчуулан “Мөнхийн үсэг” ХХК-д хэвлүүлсэн байна. Номыг Зориг сангийн номын сангаас болон www.anticorruption.mn вэбсайтаас үзэж болно.

“АСТОУХ ардчиллыг илцү өргөн фронтоор урагшлуулах зорилтод хүрэх нэг арга нь даян дэлхийн хүн ардад ардчилал болон улс төрийн эрх чөлөөний зүгт өөрсдийн орны хийж байгаа урагшлах алхмаа үнэлж цэгнэх боломж, эрх мэдлийг олгох явдал хэмээн үзэж, улс орнууд дахь түншицдтэйгээ хамтран тодорхой хүрээ, аргачиллын дагуу ардчиллын байдлыг үнэлэх хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж эхлээд байна. Нэгдсэн Вант Улсын Эссексийн Их Сургуульд анх туршсан загварыг хуучин болон шинэ тутам ардчилсан орнуудын шинжээч нартай хамтран хэлэлцэж, өөрчлөн шинэчлэх замаар боловсруулсан байна. Дэлхийн бүс нутгийг төлөөлсөн найман орны (Бангладеш, Сальвадор, Итали, Кени, Малави, Шинэ Зеланд, Перу, Өмнөд Солонгос) үнэлээчдийн баг энэхүү аргачиллыг ашиглан өөрсдийн орон дахь ардчиллын байдлыг үнэлэх туршилт явуулжээ.”

069.

М.Хоролсүрэн, Л.Янжмаа, 2005. “Цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа хөтөлбөрийн үр дүн, цаашдын хандлага; Outcomes of community policing program and future tendencies”

Ном, 178 хуудас, монгол, англи

МННХ, Унгар дахь Үндсэн хууль, эрх зүйн институт (COLPI)-тэй хамтран Монгол Улсад 1999-2005 онд хэрэгжүүлсэн “Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагаа” төслийн тайланг энэхүү номонд тусгажээ. Тайланг М.Хоролсүрэн, Л.Янжмаа нар боловсруулан ЦЕГ хэвлүүлжээ.

Төслийн зорилго нь ЦЕГ-т үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх, ЦЕГ-ыг хүчний байгууллагаас олон нийтэд үйлчилдэг байгууллага болгон хөгжүүлэхэд чиглэжээ. Цагдаагийн байгууллага авилгалд өртөх хандлагатай байдаг учраас энэ талаар сонирхсон хүмүүс хэрэгтэй мэдээллийг олж авч болох юм.

070.

УТБА, 2005. “Зүүн Азийн Барометр”

Ном, 176 хуудас, монгол

УТБА “Asian Barometer” хэмээх энэ номыг ННФ, АНУ-ын ЭСЯ-ны дэмжлэгтэйгээр орчуулан бэлтгэж хэвлүүлжээ. Зүүн Азийн болон Дэлхийн Барометрийн талаархи мэдээллийг www.eastasiabarometer.com, www.globalbarometer.com сайтуудаас болон УТБА-ийн номын сангаас олж үзэж болно.

Зүүн Азийн найман улсыг хамарсан “Зүүн Азийн Барометр” судалгааны эхний шат 2001-2003 онд явагджээ. Энэ шатны судалгаанд Хятад, Өмнөд Солонгос, Монгол, Тайвань, Тайланд, Филиппин, Япон болон Хонг-Конг хамрагдсан байна. Энэхүү судалгаа нь Латинбарометр, Африбарометр, Европын Барометрийг багтаасан Дэлхийн Барометрийн хүрээнд явагдаж буй эрдэм шинжилгээний төсөл юм. Зүүн Азийн Барометр төсөлд багтаж буй улсууд дахь судалгааг дотоодын эрдэм шинжилгээний байгууллагууд нь хариуцаж байгаа ба Монгол Улс дахь судалгааг УТБА хийж байгаа ажээ.

“... авилгын эсрэг хороо нь орчин үеийн ардчилал дахь хэвтээ хариуцлагын чухал байгууллага юм. Үр ашигтай байхын тулд энэ байгууллага нь Ерөнхийлөгч, Ерөнхий сайдаас эхлэн сайд нар, парламентын гишүүд, засаг дарга, дээд албан тушаалтан, цэрэг, цагдаагийн өндөр албан тушаалтан болон сонгогдсон, томилогдсон төрийн зохих албаныхны орлогын мэдцүлгийг хүлээж авахын зэрэгцээ, түүнд мониторинг, хяналт тавих цүргээр хангагдсан байвал зохино.”

071.

Жон Куа, 1998. “Авилгалын эсрэг тэмцэх Монгол Улсын үндэсний төлөвлөгөө”. 1998.6.29-7.1, 1998.10.16-23

Jon S.T.Quan, 1998. “National Anti-corruption plan for Mongolia (Report)”; 1998.6.29-7.1, 1998.10.16-23

Тайлан, 054-ын хуудас: 30-72, монгол, англи

Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ хамтран хэрэгжүүлж байгаа “Ардчилсан засаглалын байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд техникийн тусламж үзүүлэхээр Сингапурийн Их Сургуулийн профессор, улс төрийн шинжлэх ухааны доктор Жон Куа уригдан ажилласан юм. Профессор Жон Куа Монголд 1998.9.7-11, 1998.10.16-23-нд хоёр удаа ирж ажилласан. Түүний ажлын удирдамж дараах 2 хэсгээс тогтож байжээ: 1. Авилгалын эсрэг, шударга ёсыг хангахтай холбоотой Монголын хууль эрх зүй болон байгууллагын тогтолцоонд үнэлгээ өгөх, 2. Авилгалын эсрэг Монголын Үндэсний төлөвлөгөө (зөвлөмж) боловсруулах. Уг тайланд ажлын удирдамжаа хэрхэн биелүүлсэн тухай тодорхой өгүүлсэн байна.

“Захиргаадалтын эдийн засгаас зах зээлийн эдийн засаг руу, улс төрийн нэг тогтолцооноос нөгөө рүү шилжих нь авилгал бий болох боломж, орчныг нэмэгдүүлсэн юм. Судалгааны дүнгээс үзэхэд Монгол улс нь ядуу орон ба хүн амын 19-36% ядуу амьдралтай. Хоёрт, олон улсын жишгээр Монгол улсын төрийн албан хаагчдын цалин бага ба Ерөнхийлөгчийн, УИХ-ын тамгын газрын, Дээд шүүхийн, Үндсэн хуулийн албан тушаалтнуудын цалин 70 ам доллар байна. Гуравт, авилгалын эсрэг хууль тогтоомж хэрэгжихгүй байгаа нь авилгал бий болох бас нэгэн боломж бүрдүүлж байна. Улмаар ядуурал, төрийн албан хаагчдын бага цалин нь тэднийг авилгалд өртөхөд эмзэг болгож байгаа юм” гэж тайландаа дурьджээ.

072.

UNDP Mongolia (НҮБХХ), 1999. “Donor Assistance in Support of National Integrity Efforts”. (Үндэсний Шударга Байдлыг Дэмжихэд Донор орнууд болон Байгууллагуудын Туслалцаа)

Түгээр судалгаа, 5 хуудас, англи

НҮБХХ-ийн 1998.09.24-нд Донор байгууллагуудын дунд зохион байгуулсан уулзалтын түүвэр судалгаа.

Уг түүвэр нь Монголд үйл ажиллагаа явуулж буй донор орнууд болон байгууллагуудын үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгохын тулд тэдний хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны талаарх товч мэдээллийг чиглэл чиглэлээр нь мэдээлэл хэлбэрээр гаргажээ. Уг чиглэлүүдэд хууль, хуулийн хэрэгжилт, авилгалын эсрэг болон хариуцлагын тогтолцооны талаар, засан хүмүүжүүлэх газрын шинэчлэл, цагдаагийн газрын шинэчлэл, гаалийн албаны шинэчлэл, шүүхийн байгууллагыг чадваржуулах гэх мэт сэдвүүд багтжээ.

Уг ажлаас дээрх чиглэлүүдээр судалгаа хийж буй эрдэмтэн, судлаачид материалын нэрсийг харж уг байгууллагуудаас тодорхой мэдээлэл авч болох ба мөн донор байгууллагууд өөрсдөө болон бодлого боловсруулагчид мэдээлэл авах хэлбэрээр ашиглаж болно.

073.

S.Oyun, 1999. Developing a National Anti-Corruption Strategy: Perspective on an economy in transition

С.Оюун, 1999. Авилгалын эсрэг үндэсний стратеги боловсруулах нь: Шилжилтийн эдийн засгийн жишээ

Илтгэл, 10 хуудас, англи

1999 оны 5-р сарын 31-нээс 6-р сарын 4-нд Филиппины Манилад болсон Засаглалын Дэлхийн Бага хуралд энэхүү илтгэлийг тавьсан бөгөөд илтгэлийг www.anticorruption.mn вэбсайтаас болон Зориг сангийн номын сангаас авч үзэж болно.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт, тоталитар нийгмээс ардчилсан нийгэмд шилжих явцад учирч буй хүндрэлүүд хийгээд тэдгээр нь авилгал нэмэгдэхэд хэрхэн нөлөөлж байгаа тухай тайлбарласан байна. Өнөөгийн нөхцөл байдал болон авилгалын эсрэг хийгдэж буй үйл ажиллагааны талаар мөн дурдсан байна.

074.**Де.Спевилл, 1998. “Авилгалын эсрэг тэмцэх үндэсний хөтөлбөр”. 1998.11.23-30-нд Монголд айлчилсан шинжээч Спевиллийн тайлан****Mr. De Speville, 1998. “Report, advice and recommendations of Mr.De Speville follwing his assesment visit to Mongolia 23-30 November 1998”***Тайлан, 10 хуудас, англи*

Авилгалын эсрэг олон улсын нэртэй шинжээч Спевиллийн анх удаа 1998.11.23-30 нд Монголд ирж ажиллаад бичсэн тайлан-зөвлөмж

Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ хамтран хэрэгжүүлж байгаа “Ардчилсан засаглалын байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд профессор Жон Куа-гийн дараа, “Авилгалын эсрэг Монголын Үндэсний төлөвлөгөө (зөвлөмж) боловсруулах”-д техникийн тусламж үзүүлэхээр шинжээч Спевилль мөн уригдан ажилласан юм. Тэрээр уг асуудлаар Монголд 1998.11.23-30, 1999.1.15-25, 2000.1.14-22 нд гурван удаа ирж ажиллажээ. Уг тайланд анхны айлчлалын үр дүнг тайлагнан, холбогдох зөвлөмжийг өгсөн байна.

Энэхүү тайлан засаглал ба авилгал, НҮБХХ-ийн энэ талаар баримтлах бодлого, дотоод механизмууд, авилгалын эсрэг хөтөлбөрүүдийн жишээ, дүгнэлт гэсэн үндсэн 5 хэсгээс бүрдэнэ. Авилгал нь ядуурлын үндсэн шалтгаануудын нэг бөгөөд нийгмийн ядуу хэсэг үүнд хамгийн их өртдөг учраас НҮБХХ-өөс гишүүн орнууддаа авилгалын эсрэг тэмцэхэд нь дэмждэг тухай энэ тайлангаас танилцаж болно. Түүнчлэн судлаачийн санал болгосон авилгалын эсрэг тэмцэх үндэсний хөтөлбөрийн хувилбар болон түүний хийсэн уулзалтуудын тэмдэглэл зэргийг үзэх боломжтой.

075.**Де.Спевилль, 1999. “Авилгалын эсрэг тэмцэх Монгол Улсын Үндэсний төлөвлөгөө”****Mr. De Speville, 1999. “Mongolian National Anti-Corruption Plan” Report of Mr.B.E.D.de Speville on his second visit to Mongolia, 15-25 January 1999***Тайлан, 29 хуудас, монгол, англи*

Авилгалын эсрэг олон улсын нэртэй шинжээч Спевиллийн хоёр дахь удаа 1999.1.15-25-нд Монголд ирж ажиллахдаа бичсэн Авилгалын эсрэг тэмцэх Үндэсний төлөвлөгөө.

“... Авилгалын эсрэг тэмцэх үндэсний төлөвлөгөө боловсруулахад харгалзаж үзэх, авч үзэх, шийдвэр гаргах шаардлагтай олон тооны бодлогын асуудлууд тулгарч байгаа билээ. Эдгээрийг авч үзэх ажлыг хөнгөвчлөхийн тулд холбогдох асуудлаар нь ангилж үзэх нь зүйтэй юм. Үүнд ерөнхий асуудлууд, авилгалын эсрэг эрцүгийн хуулиудын асуудал, стратегийн хэсэг бүрт хамааралтай асуудлууд болон стратегийн

хэрэгжилтийг зохицуулах байгууллага боловсон хүчний асуудал зэрэг орж байгаа юм.” гэсэн байна.

076.

Де.Спевиаль, 1999. Авилгалын эсрэг Дээд Комиссын тухай хуулийн төсөлд өгсөн зөвлөмж

Зөвлөмж, 7 хуудас, англи, монгол

Шинжээчийн англи дээр бичсэн зөвлөмж, уг зөвлөмжийн монгол орчуулгын хамт УИХ-ын архивт хадгалагдаж байгаа. Авилгалын эсрэг Монгол Улсын 1996.4.5-ны хуулийг шинэчлэн найруулсан хуулийн олон төсөл боловсрогдсон. Эдгээрийг англи орчуулгынх нь хамт УИХ-ын архиваас, “Авилгалын эсрэг боловсруулагдсан хуулийн төслүүд” гэсэн нэртэй хавтас дотроос олж үзэж болно.

“...Улсын ба хувийн авилгалтай тэмцэх үндэсний стратеги нь улсын хэвшилээс гадна хувийн хэвшлийг хамаарах нь чухал юм. Энэхүү хоёр хэвшлийн хоорондын ялгаа нь ихэвчлэн мэдэгддэггүй бөгөөд цүнд давхар стандарт байх ёсгүй. Улсын хэвшилд ажиллаж буй ажилтны тодорхой үйлдлийг хэрэгт тооцохоос гадна хувийн хэвшлийн байгууллагын ажилтан өөрийн ахлах албан тушаалыг ашиглан авилгал авах буюу өгөхийг шаардах, авилгал өгөх явдлыг хамаарах ерөнхий зүйл байх ёстой. Авилгалтай тэмцэх дээд комисс нь улсын хэвшилээс гадна хувийн хэвшил дэх авилгалыг хамаарах хэрэгтэй.”

077.

Де.Спевиаль, 2000. “Монгол Улсын Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр”
Mr.De Speville, 2000. “The Mongolian National Anti-Corruption Plan”.
(Report of Mr.De Speville on his third visit to Mongolia, 14-22 January 2000)

Тайлан, 34 хуудас, англи

Авилгалын эсрэг олон улсын нэртэй шинжээч Спивиаллийн гурав дахь удаа 2000.1.14-22-нд Монголд ирж ажиллаад бичсэн тайлан-зөвлөмж

Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ хамтран хэрэгжүүлж байгаа “Ардчилсан засаглалын байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд профессор Жон Куа-гийн дараа, “Авилгалын эсрэг Монголын Үндэсний төлөвлөгөө (зөвлөмж) боловсруулах”-д техникийн тусламж үзүүлэхээр шинжээч Спивиаль мөн уригдан ажилласан юм. Тэрээр уг асуудлаар Монголд 1998.11.23-30, 1999.1.15-25, 2000.1.14-22-нд гурван удаа ирж ажиллажээ. Уг тайланд гурав дахь айлчлалын үр дүнг тайлагнан, холбогдох зөвлөмжийг өгсөн байна.

Тайланд Монгол улс дахь нөхцөл байдлын талаар үнэлгээ өгөөд Авилгалын эсрэг хуулийн төсөл дээр дэлгэрэнгүй саналаа өгсөн тухай, түүнчлэн энэ хуулийн төсөл нь тухайн үеийн Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуультай зохицсон эсэх болон судлаачийн 1999 оны 1-р сард боловсруулсан зөвлөмжүүдтэй тулгаж үзэхийг зөвлөсөн тухай багтаажээ.

078.

ADB-OECD, Anti-Corruption Initiative for Asia-Pacific, 2001. “Anti-Corruption Action Plan for Asia and the Pacific”.

АХБ-ЭЗХАХБ, Ази-Номхон далайн авилгалын эсрэг санаачлага, 2001.

Ази-Номхон далайн Авилгалын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө

Эмхэтгэл, 43 хуудас, англи

Ази-Номхон далайн бүсийн авилгалын эсрэг санаачлагын гишүүний хувьд Монгол улс энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөг дэмжин ажиллаж байгаа бөгөөд 2001 оны 11-р сарын 28-30-нд Токио хотноо болсон 3-р хуралд Монгол улсаас Япон улсад суугаа элчин сайд З.Батжаргалын хэлсэн үгийг 31-р хуудсаас үзэж болно.

Эмхэтгэлд тус санаачлагаас баталсан авилгалын эсрэг явуулах үйл ажиллагааны үндсэн гурван чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон гишүүн орнуудын зүгээс хамтран ажиллаж хүлээсэн үүргээ биелүүлэх тухай амлалтуудыг багтаажээ.

079.

Зориг сан, 2001. “Авилгал ба төрийн албан хаагчид”

Төслийн тайлан: 4 хуудас, монгол, англи

Азийн сангийн санхүүжүүлэлтээр Засгийн Газрын ХЭГ-тай хамтран зохион байгуулсан цуврал семинарийн тайланг www.zorigfoundation.org.mn, www.anticorruption.mn вэбсайтуудаас үзэж болно.

Төслийн хүрээнд шинээр томилогдсон төрийн албан хаагчдын дунд авилгал, түүний тодорхойлолт, тэмцэх арга замууд сэдвээр ЗГХЭГ-тай хамтран цуврал семинарууд зохион байгуулсан. Семинарт авилгалын эсрэг идэвхтэй ажиллаж буй Монголын улс төрчид, мэргэжилтнүүд болон нийгмийн зүтгэлтнүүд илтгэл тавьж хэлэлцүүлсэн бөгөөд итгэлүүдийн эмхэтгэлийг хэвлүүлэн олон нийтийн хүртээл болгожээ.

080.

Robert La Mont, 2002. Some Means of Addressing Judicial Corruption in Mongolia

Роберт Ла Монт, 2002. Монголд нүүрлээд буй шүүхийн авилгалын талаархи зарим асуудлууд

Судалгааны материал, 8 хуудас, англи

Судалгааны ажлыг Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрөөс авч болно. Хаяг: ХЗДХЯ, 216 тоот. Имэйл: ncsc@magicnet.mn

Уг судалгаа нь Монголын шүүхийн систем нь яагаад авилгалд автсан ямархуу байдлаар оршин тогтнож байгаа талаархи үнэлгээг хийсэн бөгөөд шүүхийн систем дэх авилгалыг бууруулснаар бусад салбарын авилгалтай тэмцэж эхлэх нааштай алхам болох талаар дурьдан мөн олон нийтээс авсан авилгалын талаархи судалгаанд шүүхийн авилгалын эзлэж буй хувийг оруулж өгчээ. Мөн шүүхийн систем дэх авилгалыг хэрхэн бууруулах болон авилгачдыг хэрхэн илчилж, шийтгэж болох талаархи зөвлөмжүүд, мөн бусад оронд хэрхэн тэмцдэг талаархи жишээг оруулсан байна. Монголын нийгэм дэх хүнд суртал, авилгал нь урт удаан хугацааны гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх боломжуудыг хааж байгаа ба ингэснээр эдийн засгийн хөгжил болон ажлын байрны өсөлтөд муугаар нөлөөлж байгаа талаар дүгнэлт хийжээ.

Энэ судалгаа нь авилгалын талаар судалгаа хийж буй оюутан залуучууд, эрдэмтэн судлаачдад шинэлэг санаа өгөхүйц ач холбогдолтой. Мөн шүүхийн авилгалыг бууруулахад нөлөөлж чадахуйц зөвлөмжүүдийг оруулж өгснөөрөө бодлого боловсруулагчид болон авилгалын эсрэг тэмцэх байгууллагад санаа авахуйц судалгаа болжээ.

081.

Засгийн газрын Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал, 2003.

“Авилгалын эсрэг цуврал уулзалт, ярилцлагын товч тэмдэглэл”

Эмхэтгэл, 113 хуудас, монгол

Уг эмхэтгэлийг Засгийн газрын ХАБХСЗ хөтөлбөрөөс 2003 онд гаргасан ба Зориг сангийн номын сангаас авч үзэж болно.

Эмхэтгэлд энэхүү хөтөлбөрийн хүрээнд зохиогдсон дараах 4 уулзалт ярилцлагын товч тэмдэглэл оржээ: 1. Авилгалын эсрэг тэмцэлд иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн үүрэг (Улаанбаатар, 2002.11.01); 2. Авилгалын эсрэг тэмцэлд хууль тогтоогчдын үүрэг оролцоо (Улаанбаатар, Их тэнгэр, 2002.12.21); 3. Авилгалын эсрэг тэмцэлд хувийн хэвшлийн үүрэг (Улаанбаатар, 2003.01.24); 4. Авилгалын эсрэг тэмцэлд гүйцэтгэх засаглал, шүүх эрх мэдлийн гүйцэтгэх үүрэг (Улаанбаатар, 2003.03.06). Эдгээр илэн далангүй ярилцлагын хоёр дахь нь УИХ-ын зарим гишүүдийг ихэд цочирдуулан



хэвлэл мэдээллээр шуугиан тарьж байлаа. Эмхэтгэлийг 2003 онд болсон “Авилгалын эсрэг Үндэсний бага хурал” дээр бусад материалын хамт олшруулан тараасан юм.

082.

Нээлтэй Нийгэм Форум, С.Баяраа. 2005. “Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахын эсрэг авах арга хэмжээ”. Судалгааны ажлын тайлан ба бодлогын зөвлөмж

S.Bayaraa (Open Society Forum’s Policy Fellow), 2005. “Administrative Remedies for Government Abuses” Policy research paper and policy recommendations
Судалгааны тайлан, 59 хуудастай, монгол, англи

ННФ-ын Хөгжлийн мэдээллийн төв, Төв номын сан, Зориг сангийн номын сангуудаас болон www.forum.mn вэбсайтаас авч үзэж болно.

ННФ-ын бодлогын судлаач С.Баяраагийн судалгааны ажилд төв болон орон нутгийн түвшинд төрийн эрх мэдлийг урвуулан ашиглах явдал түгээмэл байгаа бөгөөд хяналтгүй болсон нь дараах шалтгаантай гэж үзжээ, үүнд: 1/ төрийн захиргааны бодлого боловсруулан шийдвэр гаргах үйл явцад иргэдийн зүгээс оролцох албан болон албан бус арга механизм үгүйлэгдэж байгаагаас тэдний оролцоо бага байгаа, 2/ мөрдөгдөж буй хууль тогтоомж зохих түвшинд хийгдээгүй, үр ашигтай үйлчлэхгүй, хэрэгжихгүй байна, 3/ түүхэн болон соёлын уламжлалт хүчин зүйл төрийн албанд нөлөөлсөн хэвээр байгаа учраас төрийн албаны гол утга учир, үүрэг нь ард түмэнд үйлчлэх явдал гэсэн ойлголт төрийн албан хаагчдын сэтгэхүйд хэвшээгүй байна, 4/ иргэд, иргэний нийгмийн зүгээс төрийн байгууллага, албан хаагч, захиргааны актын талаар шүүхэд гомдол гаргах туршлага хомс байна гэжээ. Судалгааны баримт бичигт төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахын эсрэг авах арга хэмжээнүүдийн талаар судлаачийн зөвлөмж оржээ.

083.

U.S.Ambassador to Mongolia, Pamela J.Slutz, April 06 2005. United States-Mongolia Relations: A New Era of Comprehensive Partnership

АНУ-с Монголд суугаа элчин сайд Памела Слutz, 2005 оны 4-р сарын 6.

АНУ-Монголын харилцаа: Олон талт харилцааг хөгжүүлэх шинэ үе

Илтгэл, 7 хуудас, англи

Илтгэлийг www.asiasociety.org/speeches/dc_slutz05.html хаягаар үзэж болно.

Уг илтгэлд Америк-Монголын олон талт харилцааны талаар дурьдсан бөгөөд үүний дотор Монголын ардчилал, сайн засаглал, авилгалын талаархи одоогийн нөхцөл байдлын талаар дурьдаад мөн Монголд нүүрлээд байгаа ядуурал нь авилгалтай шууд холбоотой мөн энэ нь олон улсын байгууллагууд болон донор орнуудаас орж ирж буй тусламж үр

дүнгүй болж байгаагийн нэг шалтгаан гэж дурьджээ.

Илтгэл нь Монгол-АНУ-ын олон талт харилцааны талаар сонирхож буй оюутан залуучууд, судлаачид, улс төрчдөд мэдээлэл болохоос гадна монголын авилгалын одоогийн нөхцөл байдлыг товч дурьдан цаашид хийхээр төлөвлөөд буй ажлын талаар оруулжээ.

084.

UNDP, Feb, 2004. Anti-Corruption, Practice Note, Final Version
НҮБХХ, 2004 оны 2-р сар. Авилгалын Эсрэг, Практик Мэдээлэл, Эцсийн хувилбар

Практик мэдээлэл: 35 хуудас, англи

Электрон хувилбарыг доорх хаягаар үзэж болно.
www.aba-asia.com/resourceToolkit/undp_PracticeNote_anticorruption.pdf

1997 оноос хойш НҮБ нь ардчилсан засаглалыг бий болгоход түлхэц болох ил тод байдал, хариуцлагын тогтолцоо, шударга байдал болон авилгалын эсрэг үйл ажиллагааг дэмжсэн хөтөлбөрүүдийг явуулсаар ирсэн. Энэ практик мэдээлэл нь шинэ мэдлэг, шинэлэг санааг дэмжих түүнчлэн өөртөө итгэх итгэл болон хариуцлагыг бий болгох маягаар байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх талаархи саналуудыг оруулсан ба мөн сонирхлын бүлгүүдийг оролцуулан нээлттэй ярилцлага өрнүүлэн засгийн газрыг тохиромжтой сайн бодлого боловсруулахад нь туслах үйл ажиллагааг дэмжих талаар дурьдсан байна.

Уг ажил нь ил тод байдал, хариуцлагын тогтолцоо, шударга байдал гэж юу болох мөн авилгалын эсрэг ямар үйл ажиллагаа явуулж болох талаархи зөвлөмжүүд мөн НҮБ-ын дээрх сэдвүүдээр ажиллаж байсан туршлагыг багтаажээ. Мөн эндээс авилгалын эсрэг үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, авилгалын эсрэг конвенциуд мөн холбогдолтой чухал баримт бичгүүдийг агуулсан байгууллагуудын интернэт хаягийг оруулжээ.

085.

Overseas Development Institute, 2000. World Governance Survey in Mongolia
Олон улсын хөгжлийн хүрээлэн, 2000. Монгол дахь засаглалын судалгаа

Судалгааны тайлан, 6 хуудас, монгол, англи

Электрон хувилбарыг доорх хаягаар үзэж болно.
www.odi.org.uk/wga_governance/Docs/WGS-discussionPaper3.pdf

Дэлхийн засаглалын судалгааг анх 1999 онд Жулиус Корт санаачлан хөгжиж буй 16 орныг хамруулжээ. Хоёр дахь шатанд нийт 50 орныг хамруулсан бөгөөд засаглалыг хэрхэн үнэлэх вэ? Байршил болон цаг хугацаанаас хамааран хэрхэн өөрчлөгдөж байна

вэ? гэсэн асуултуудад хариу авч улс орнуудыг хооронд нь харьцуулах оролдлого хийжээ. Энэхүү судалгааны тайлангаас манай орны засаглал, тухайлбал төр засгийн нээлттэй байдал, хариуцлагын тогтолцоо, төрийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар судлаачид ямар дүгнэлт өгснийг олж мэдэж болно.

086.

The World Bank, Governance Matters III: Governance Indicators for 1996-2002, 2003

Дэлхийн Банк, Засаглалын асуудлууд III: Засаглалын шалгуур үзүүлэлтүүд 1996-2002, 2003

Судалгааны тайлан, 116 хуудас, англи

Электрон хувилбарыг дараахь хаягаар үзэж болно. www.worldbank.org/wbi/governance/govdata2002/

Дэлхийн банкнаас гаргасан энэхүү тайланг Дэлхийн банкны Даниэл Кауфман, Арт Крэй, Массимо Матрузи нарын судлаачид бэлтгэжээ. Монгол улсыг оролцуулан дэлхийн 199 орны засаглалыг 1996, 1998, 2000, 2002 онуудын байдлаар үндсэн 6 шалгуур үзүүлэлтээр харьцуулан дүгнэсэн байна. Ингэхдээ 18 өөр байгууллагаас бэлтгэсэн 25 төрлийн мэдээллийн эх үүсвэрийг ашиглажээ. Үндсэн 6 шалгуур үзүүлэлтэд хууль дээдлэх ёс, засгийн газрын үр дүнтэй байдал болон авилгалыг хянаж буй байдал багтсан тул энэ талаарх мэдээллийг тайлангаас үзэж болно.

087.

Ts. Altanzaya Tserendondov, Mongolia, 2001. Corruption in privatization and effective anti-corruption strategies in transition country-Mongolia

Ц.Алтанзаяа, Монгол, 2001. Хувьчлал дахь авилгал, шилжилтийн үеийн Монгол дахь авилгалын эсрэг үр дүнтэй стратеги төлөвлөгөө

Өгцүлэл, 5 хуудас, англи

2001 онд Чех улсын Прага хотноо ТИ-ээс зохион байгуулсан Олон улсын авилгалын эсрэг 10-р бага хурлын хүрээнд зохиогдсон Оюутан залуусын чуулганд энэхүү илтгэлээр оролцжээ. Электрон хувилбарыг дараах хаягаар үзэж болно. www.10iacc.org

Энэ өгүүлэл нь хувьчлалын асуудалд тулгараад байгаа авилгалын асуудлыг шийдэхэд авч болох олон талт арга хэмжээг дурьдсан бөгөөд үүнд хувьчлалын салбарт хийсэн судалгаа, шинжилгээний болон туршилтын ажлуудын талаар оруулжээ. Монгол шиг шилжилтийн үеийн улс оронд хувьчлалын үйл явц дахь авилгалтай хэрхэн тэмцэх түүний ул үндэс, суурийг ойлгоход туслах болно. Өгүүлэл нь мөн Монголын одоогийн хувьчлалын

НОМ ЗҮЙ

үйл явц мөн хувьчлалд тохиолдож болох авилгалтай тэмцэхэд мөрдөх журам горимыг оруулжээ.

Уг өгүүлэл нь хувьчлал түүнтэй холбоотойгоор гарч ирэх авилгалын асуудлыг сонирхож буй судлаач, шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдад мэдээллийн чанартай болон сургамж өгөхүйц материал болжээ.

088.

Хүний эрхийн боловсролын төв, “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлэх нь”

Зөвлөмж: 8 хуудас, монгол

МННХ-ийн санхүүгийн дэмжлэгээр хэрэгжүүлсэн “Хуулийн байгууллагуудын ил тод, нээлттэй байдлыг хангах асуудал” төслийн хүрээнд явуулсан санал асуулга дээр үндэслэн зөвлөмж боловсруулсан байна.

“...Хуулийн байгууллагын үйл ажиллагаа тэр бцр ил тод нээлттэй явагддаггүйгээс ажилтнууд нь хээл хахууль авилгалд өртдөг гэж олон нийтийн зүгээс үздэг талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр багагүй ишцүмжлэл нийтлэгдэж байгаа төдийгүй тодорхой хэргийн талаар иргэдээс санал гомдол, мэдээлэл цөөн бус гарч, хууль ишцүхийн өмнө хүн бцр тэгш эрхээ эдлэж чаддаггүй гэсэн ойлголт төрцүлдэг.” гэж зөвлөмждөө үзсэн байна.

089.

МУ-ын Үндсэн Хуулийн Цэц, 2005. “Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн шийдвэрийн эмхэтгэл 1, 2”

Ном,эмхэтгэл 1, 296 хуудас, эмхэтгэл 2, 283 хуудас, монгол

Үндсэн хуулийн Цэц өөрийн гаргасан 1992-2000 оны шийдвэрийн эмхэтгэлийг ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан түүний монгол дахь суурин төлөөлөгчийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр хоёр боть болгон 2005 онд хэвлүүлжээ. Өмнө нь 2000 онд мөн ийм хоёр боть эмхэтгэлийг хэвлүүлсэн байна.

Үндсэн хуулийн Цэцийг Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу анх 1992 оны хавар байгуулсан юм. Цэцийн үйл ажиллагааг Үндсэн хууль, Цэцийн тухай хууль, Цэцийн процессын хуулиар үндсэндээ зохицуулдаг. Цэцийн энэхүү хоёр боть эмхэтгэлд 2000 он дуусах хүртэл хугацаанд гарсан бүх шийдвэр нь орсон.

Цэц бол ҮШЕТ-ны тулгуур багануудын нэг болох шүүх эрх мэдлийн хүрээнд хамаарах байгууллага. Ардчиллын үнэт зүйл болох хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэхэд Цэцийн шийдвэрүүд хэрхэн нөлөөлдөг, Цэцийн шийдвэр хэр үндэслэлтэй гардаг,

Цэц бүрэн эрхээ хэр зэрэг хэрэгжүүлдэг талаар энэ номноос бодитой мэдээлэл авах боломжтой. Цэцийн нилээд шийдвэр мөн чанартаа авилгалтай холбоотой асуудлаар гарсан байдаг.

090.

UB Post, 2002. Question Time: Is this why the Anti-Corruption bill has been shelved for two years?

Улаанбаатар Пост, 2002. Асуултын Цаг: Авилгалын Эсрэг Хуулийн төсөл яагаад батлагдахгүй 2 жил хойшлогдох болов оо?

Өгцлэл, 2002 оны 12-р сарын 9 №.51, 4-р нүцрт

Уг асуултын цаг булан нь авилгалд өртөгдсөн байж болох төрийн өндөр албан тушаалтнууд, УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүдийн зургийг хаанаас ямар хэлбэрээр авилгал авсан байж болох талаар асуулт хэлбэрээр асуудал дэвшүүлэн тавьжээ. Мөн түүний доод талд авилгалын эсрэг хуулийн төслийг авч хэлэлцэх гэж буй талаар, авилгалын эсрэг биеэ даасан байгууллага байгуулагдах тухай мэдээлэл тавигджээ.

Уг мэдээлэл нь авилгачид болон авилгал авсан байж болох төрийн өндөр албан тушаалтны талаарх мэдээлэл цуглуулж буй хүмүүст батлагдаагүй ч гэсэн тодорхой эх сурвалж болж болох талтай.

091.

“Үнэн” сонин, 2003. Ц.Эрдэнэбат. “Авилга өгдөг, авдаг тодорхой хүмүүсийг шалгаж байна”

Ярилцлага, 2003.04.18 №077, 5-р нүцрт

Улсын мөрдөн байцаах газрын дэд дарга, цагдаагийн дэд хурандаа Ц.Эрдэнэбаттай сэтгүүлч Д.Батзаяагийн хийсэн ярилцлага. Мэргэжлийн байгууллагын эрх бүхий албан тушаалтантай хийсэн ярилцлага.

“Хууль хяналтын байгууллагынхан авилгалд их өртөмтгий гэж ярьдаг. Та цүнд ямар дүгнэлт хийж байна?, Авилгал хээл хахуулийн гэмт хэрэгтэй тэмцэхэд Улсын мөрдөн байцаах газар голлох цүрэг гүйцэтгэх байх л даа. Тиймээс өнөөдөр танайд энэ чиглэлээр шалгагдаж буй хэргүд хэр олон байгаа вэ?, Тэд мэдээж эрх мэдэлтэн, албан тушаалтанууд уу?, Мөрдөн байцаах газрын дэд дарга, энэ талын гэмт хэргийг хариуцдагийн хувьд авилгалтай хэрхэн тэмцвэл цр дүнд хүрнэ гэж боддог вэ” гэсэн асуултуудаар ярилцлага хийсэн байна.

092.

“Өдрийн сонин”, 2003. Л.Жавзмаа /МУ-ын Ерөнхий Аудитор/. “Авилгал бол эдийн засгийн чадавхийг сульдаагч”

Өгцүлэл, 2003.05.12 №114, 2,5-р нүцрт

Төр, засгийн бүтцийн 11 байгууллагын жагсаалтаас авилгал хамгийн их авдаг гэдэгт гаалийнхан, шүүхийнхэн болон банк, татвар, цагдаагийнхныг нэрлэж байна. Эндээс авилгал гэгч гаж үзэгдэл манай нийгэмд бодитой оршиж, төрийн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх болон нийгмийн дэг журмыг хангах үүрэгтэй бүтцүүдэд ч нэвтэрсэн байж болзошгүй харагдаж байна. Аудитын төв, орон нутгийн байгууллагууд авилгалаас урьдчилан сэргийлэх ажлыг хийх учиртай талаар нийтлэлд дурджээ.

093.

“Үнэн” сонин, 2003. Д.Заяа. “Боловсрол дахь авилгыг хэн өөгшүүлдэг вэ?”

Өгцүлэл, 2003.09.16 №184, 5-р нүцрт

Өнөөдөр авилгад нийтээр дасамгай хэвээрээ, авилгыг үл тэвчих нийгмийн сэтгэл зүй үүсээгүйгээс гадна түүний эсрэг тэмцэлд иргэдийн оролцоо, байр суурь тийм ч идэвхтэй бус байна. Ийнхүү дүгнэж буй учир гэвэл энэ намрын сургууль, цэцэрлэгийн элсэлтийн цээр “гар цайлгах”, “хандив”, “сэтгэлийн бэлэг” гээч нь даамжирч, авилгалын өртөг нэмэгдсэн нь ажиглагдлаа.

Боловсролын салбар судалгаагаар авилгалд өртөмтгий байгууллагаар байнга дээгүүрт ордог бөгөөд Д.Заяа өгүүлэлдээ энэхүү асуудлыг хөндсөн байна.

094.

“Өдрийн сонин”, 2003. Д.Мөнгөндалай. “Шүүх, гааль авилгалд өртдөг үү?”

Өгцүлэл, 2003.12.24 №309, 2-р нүцрт

Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохицуулж, хяналт тавих Үндэсний зөвлөлийн хуралдаан дээр Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохиож буй ажлын явцын тухай Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч Ч.Ганбат, Гаалийн ерөнхий газрын зохиож буй ажлын талаар Гаалийн ерөнхий газрын дарга Х.Баатар нар мэдээлсэн тухай энэхүү өгүүлэлд бичжээ. Тус байгууллагын удирдлагууд авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгууллагууд дээр хийгдэж буй ажлынхаа явцын талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийснийг эндээс уншиж болно.

095.

“Өнөөдөр” сонин, 2004. Д.Цэрэндорж. “Улс төрийн хүрээний Авлига сонгуулиас эхэлдэг”

Ярилцлага, 2004.01.09 №006, 5-р нүцрт

Авилгатай нийтээрээ тэмцье “Өнөөдөр”-ийн сэдвийн ярилцлагад “Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал” хөтөлбөрийн үндэсний менежер Д.Цэрэндоржтой сэтгүүлч Д.Бэхбаярын хийсэн ярилцлага. Төр, засгийн хэмжээнд авилгалтай тэмцэхэд үндэсний хэмжээнд ямар ажил зохион байгуулж явуулж буйг Д.Цэрэндоржтой хийсэн ярилцлагаас уншиж болно.

“...Монгол Улс авилгад идэгдсэн орны жагсаалтад ордог. Манайд авлигын торон сүлжээ хэрснийг бүгд л хүлээн зөвшөөрч байгаа. Ийм байдал юунаас цүссэн улбаатай вэ?, Бусад улс орон авилгын эсрэг хатуу тэмцдэг. харин манай төр, засгийн хүмүүс яриад л байдаг. Бодит байдал дээр хэрэгжиж байгаа нэг ч зүйл харагдахгүй юм?, Төр, засгийн хүмүүс өөрсдөө авлигад идэгдсэн учраас түүний эсрэг хүчтэй тэмцэж чаддаггүй гэж ярьдаг. Хэрвээ дорвитой тэмцээд ирвэл өөрсдийнх нь идсэн уусан бүхэн бултайх гээд байдаг бололтой?, Өнгөрсөн жил авилгатай тэмцэх чиглэлээр олон семинар уулзалт зохион байгуулсан. Үүний үр дүн гарсан уу?” гэх мэт асуултуудаар ярилцлага хийсэн байна.

096.

“Өдрийн сонин”, 2004. Д.Мөнгөндалай. “Авилгалтай хэрхэн тэмцэх вэ?”

Өгцүлэл, 2004.01.23 №19, 2-р нүцрт

Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр батлагдсан ч шинэ хууль нь батлагдахгүй байгаа учраас эрх зүйн орчин бүрдэж өгөхгүй байгаа шалтгааны талаар нийтлэлдээ өгүүлжээ.

“...Авилгалтай тэмцэх үндэсний зөвлөлд тодорхой албан тушаалтан дарга нарын төлөөлөл байдаг. Түүн дээр нь төрийн бус байгууллагын төлөөлөл нэмэгдэнэ. Тэдэнд тэр бүр ажлаа хаяад авилгалтай тэмцээд явах уу, зав боломж бий бил үү. Үүнээс харахад Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр маань олон биелэгддэггүй хөтөлбөрүүдийн нэг болчих вий гэсэн эмзэглэл төрж байна.”

097.

“Үнэн” сонин, 2004. Б.Мөнхтуяа. “Авилга илчлэгддэггүйн гол гогцоо нь хуульдаа байгааг амьдрал харуулж байна”

Өгцүлэл, 2004.02.10 №28, 3-р нүцрт

“...Ханцуйнаас ханцуй руу шууд ордог, бусдын нүдэнд үзэгдэж, гарт

баригддаггүйгээрээ авилга нь хамгийн нууцлагдмал үйлдэлд тооцогддог. Ер нь авилгын талаархи судлаачдын бичсэнээс үзвэл энэ гэмт үйлдэл нь төр үүссэн цагаас гараагаа эхэлж өдийг хүрсэн гэх. Мэдээллийн сүлжээгээр авилгыг илчлэх бодит боломжтой.” гэсэн санааг энэхүү нийтлэлд дэвшүүлсэн байна.

098.

“Үнэн” сонин, 2004. Б.Мөнхтуяа. “Эвслийн засгийн газар авилгалтай хэрхэн тэмцэх бол”

Өгцүлэл, 2004.09.08 №177, 5-р нүцрт

“...Монголчууд хязгаарлагдмал хэрэглээтэй тарчигхан амьдрал нь авилгалыг өдөөх хөрс суурь болдог гэхээс өөр үнэнд нийцэх хариулт олдохгүй нь. Бид чинь бусдын адил тансаг биш юмаа гэхэд хэрэгцээгээ хангаад байхуйц хэрэглээтэй, төр хэрэглээгээ бий болгохуйц санхүүгийн чадавхитай байх ёстой. Тэр чадавхийг төр иргэддээ өгч чадахгүй болохоор иргэд өөрсдөө бий болгохоос өөр зам үгүй. Тэр авилгын зам. Монголчууд авилгыг хэрхэн төсөөлдөг вэ? Авилга хаана бугшиж байна вэ? Төр ямар оролцоотой вэ?” гэсэн сэдвүүдээр авилгалын асуудлыг хөндсөн байна.

099.

“Үнэн” сонин, 2005. Т.Буд. “Авилгал, ядуурал хоёр ихэр юм шүү?”

Өгцүлэл, 2005.03.01 №039, 5-р нүцрт

“...Манайханд Авилгалтай тэмцэх хуулиа батлаад, тусгай байгууллага байгуулчих л юм бол тэмцлийн утга учир бүрэн тайлагдах юм шиг ойлголт бий. Хууль, байгууллага мэдээж чухал. Гэхдээ энэ нь авилгалын эсрэг тэмцлийг хойшлуулаад байх шалтгаан бас биш байх. Төр, засаг өөрөө авилгалтай хэрхэн тэмцэж буйгаа харуулах, сонсгох цаг болж. Засгийн газар ядууралтай дайн зарлахаа илэрхийлсэн бол одоо авилгалтай дайн зарлаж байгаагаа олон нийтэд зарлаж эдийн засгийн үр ашигтай байдлыг бий болгох хэрэгтэй.” гэсэн санаа илэрхийлсэн байна.

100.

“Өнөөдөр” сонин, 2005. Ө.Энхтөр. “Авлигын эсрэг хуультай больё гэдэг мөртлөө...”

Ярилцлага, 2005.04.21 №094, 3-р нүцрт

Авилгатай нийтээрээ тэмцье “Өнөөдөр”-ийн сэдвийн ярилцлагад Улсын мөрдөн байцаах газрын Албан тушаал, зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдөх хэлтсийн дарга, дэд хурандаа Ө. Энхтөртэй сэтгүүлч Д. Заяабатын хийсэн ярилцлага.

“...Улс төрийн зарим нам эвсэл, хөдөлгөөний зүгээс цагдаагийн байгууллага авлига, хээл хахуулийн хэргийг илрүүлж, шалгахад хойрго хандаж байгаа, Тэр ч бүү хэл нэр бүхий хүмүүстэй холбоотой хэргийг дарагдуулж буй талаар ярьж бичих болсон. Үүнд та ямар тайлбар өгөх вэ?, Цагдаагийн байгууллага тухайлбал, танай хэлтсээс авилга, хээл хахуультай холбоотой хэчнээн хэргийг сүүлийн үед шалгаж шийдвэрлээд байна?, Манайд гарч байгаа хээл хахуулийн гэмт хэргийн гол шинж нь юу байна вэ. Өөрөөр хэлбэл материаллаг, материаллаг бус шинжийн аль нь давамгайлдаг юм бол?, Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөж буй хуулиар авлигын хэргийг илрүүлэн шийтгэл ногдуулах боломж хэр байна вэ?” гэх мэт асуултуудаар ярилцлага хийсэн байна.

101.

“Зууны мэдээ” сонин, 2005. Б.Самбуу. “Авилгалтай тэмцэх алтан боломж яг одоо л байна”

Өгцүлэл, 2005.05.02 №101, 3-р нүүрт

“...Амтай болгон нь авилгалын талаар янз бүрийн үг унагах дуртай болсны бас нэг шалтгаан нь удахгүй болох ерөнхийлөгчийн сонгуулийн кампани хүчээ авч байгаатай холбоотой. Нэр дэвшигч хот, хөдөөгүүр давхиж олон түмэнтэйгээ уулзаж мөрийн хөтөлбөрөө тайлбарлахаараа нийгэмд бугшсан аль л болж бүтэхгүй үзэгдлийг бууруулна, багасгана, арилгана гэхээр өнөөх л архидалт, ядуурал, ажилгүйдэл, авилгал гэсэн үгс өөрийн эрхгүй амнаас нь унадаг биз.” Олон намын парламент, хамтарсан засгийн газар нийлээд авилгалтай тэмцэх аятай боломж бүрдээд байгааг сануулсан байна.

102.


“Өдрийн сонин” сонин, 2005. Памила Слуц /АНУ-ын Элчин сайд/.

“Монголд авилга байгаад зогсохгүй улам томорч байна”

Илгээлт, 2005.05.11 №115, 3-р нүүрт

“Авилгалын эсрэг НҮБ-ын конвенц” бага хуралд АНУ-ын Элчин сайд Памила Слуцын илгээлт.

Монгол Улс “Мянганы сорилтын сан”-гаас цаашид дэмжлэг авч чадах эсэх нь Монгол Улсын төр засаг авилгалын эсрэг хүчтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэгтэй хэр нухацтай хандаж, иргэдийнхээ санааг зовоож буй асуудлыг яаж авч үзэж байна вэ гэдгээс нэг талаар шалтгаалах юм.



103.

“Ардын эрх” сонин, 2005. Г.Отгонжаргал. “Монгол улсад нэг сая 200 мянган хүн авилгал авдаг”

Өгцүлэл, 2005.06.03 №108, 8-р нүцрт

Сонгуулиар нэр дэвшигчид янз бүрийн амлалт, янз бүрийн хэлбэрээр авилгал өгдөг талаар нийтлэлдээ өгүүлжээ.

“Ард түмэн хязгааргүй эрх мэдэлтэй. Харамсалтай нь өөрсдийн эрх мэдлээ зүцэм талх худалдаж авахад л зориулдаг. Зориулалт нь хэтэрхий хямдхан. Хямдхан учраас түүнийг худалдан авахыг хүсдэг хүн нь ч бага. Ердөө л эрх мэдлийн төлөөх хүсэл тэмцүүлэлтнүүд.”

104.

Өдрийн сонин, 2005. Л.Жавзмаа /МУ-ын Ерөнхий Аудитор/. “Авилга залилангийн арга улам нарийсч, олшрох хандлагатай байна”

Өгцүлэл, 2005.10.24 №255, 2,7-р нүцрт

Азийн Хөгжлийн Банкнаас гаргасан авилгатай тэмцэх бодлогын баримт бичигт “Авилга нь төрийн болон хувийн хэвшлийн албан хаагчид өөрийн албан тушаалыг урвуулан ашиглаж буюу бусдад нөлөөлснөөр өөрсдийгөө, ойр дотныхоо хууль бусаар баяжуулах буюу бусдыг цунд өдөөх явдлыг хамаарна” гэж тодорхойлсон байна.

105.

“Ардын эрх”, 2005. Ц.Элбэгдорж /МУ-ын Ерөнхий Сайд/. “Миний ял, гавьяаг хоёрыг хойч үе шүүнэ”

Ярилцлага, 2005.10.24 №208, 1,2,4-р нүцрт

Монгол Улсын Ерөнхий Сайд Ц.Элбэгдоржтой “Ардын эрх” сонины сурвалжлагч Л.Мөнхбаясгалангийн хийсэн ярилцлага.

“Одоо авилгалтай тэмцэх цүйл ажиллагаагаа бодит ажил хэрэг болгоё, бодит алхмууд хийж эхэлье гэж ярилцлаа. Эхлээд, авилгал гэж юу байдаг юм бэ, ямар хэмжээнд хүрсэн, яах ёстой юм гэдэг талаар ярих шаардлагатай байсан. Харин одоо ярих хугацаа дууссан гэж ойлгож болно.”

3

АВИЛГАЛ БА ИРГЭНИЙ НИЙГЭМ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

106.

Нээлтэй Нийгэм Форум, Сонгогчдын Боловсролын Төв, Глоб Интернешнл, 2004. “2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг”

Судалгааны тайлан, 72 хуудас, монгол

Сонгогчдын боловсрол төв, Глоб Интернейшнл, Нээлтэй Нийгэм Форум ТББ-ууд хамтран сонгуулийн кампанит ажлын хуулиар тогтоосон хугацаанд (2004.4.26-6.26) мониторинг явуулж түүний дүнг хэвлүүлжээ. Судалгааны тайланг ННФ-ын Хөгжлийн Мэдээллийн төвөөс үзэж болно. Вебсайт: www.forum.mn, Имэйл: osf@soros.org.mn

Сонгуульд өрсөлдөгч намууд өөрийн сурталчилгаанд 1. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг хэрхэн ашигласан, 2. Төрийн мэдлийн эх үүсвэрийг хэрхэн урвуулан ашигласан талаар санхүүжилтийн мониторинг хийжээ. Үүнд 5 телевиз, 2 радио, 10 сонингийн нийтэд зориулсан материалыг тасралтгүй хянан бүртгэх, нэр дэвшигч болон түүний дэмжигчид сонгуулийн сурталчилгаанд төрийн мэдлийн эх үүсвэрийг хэрхэн урвуулан ашиглаж байгааг хот хөдөөгийн 13 засаг захиргааны нэгжид бүртгэн баримтжуулсан аж. Тайланд тодорхой жишээ болон зөвлөмжийг хавсаргасан байна. Мониторингийн дүн сонгуультай холбогдсон улс төрийн хүрээний авилгал санаа зовоох хэмжээнд хүрснийг харуулж байна.

107.

Дэлхийн Банк, Кармен Малена, Райнер Форстер, Жанмежэй Сингх, 2004. “Нийгмийн хариуцлага: Үзэл баримтлал, шинээр гарч буй практик”

Ном, 34 хуудас, монгол, англи

(Carmen Malena, Reiner Forster, Janmejay Singh “Social Accountability: An Introduction to the Concept and Emerging Practice”) хэмээх товхимол нь Дэлхийн Банкны БНТХ сүлжээнээс боловсруулан хэвлүүлдэг “Нийгмийн хөгжлийн илтгэлүүд, нийгмийн оролцоо” цувралын 2004 оны 76-р илтгэл юм (The World Bank, Social Development Papers: Participation and Civic Engagement, Paper 76, December 2004). Дэлхийн Банк товхимолын монгол орчуулгад англи эхийг хавсарган хэвлүүлжээ. Харилцах И-мэйл хаяг: sdccommunications@worldbank.org

Илтгэлийн агуулга нь ядуурлыг бууруулах, үр ашигтай бөгөөд тогтвортой хөгжлийг хангах Дэлхийн Банкны зорилгоос үүдэлтэй аж. Илтгэлд (1) нийгмийн хариуцлага гэж юу болох, (2) ямар учраас чухал, (3) ямар үндсэн шинжтэй, (4) хаана яаж хэрэглэдэг, (5) амжилтанд хүргэх ямар хүчин зүйл байдаг гэсэн таван гол асуудлыг авч үзсэн байна. Нийгмийн хариуцлага гэдэг нь нийгмийн оролцоонд тулгуурлан хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх хандлага юм гэж тодорхойлжээ. Албаны хүмүүст хариуцлага

хүлээлгэх өргөн хүрээний үйл ажиллагааг иргэд, тэдний хамтлаг, хараат бус хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллага явуулна гэсэн үг аж. Эдгээр үйл ажиллагаанд төсөв зохиох, улсын төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, төрийн үйлчилгээнд мониторинг хийх, эрэн сурвалжлах сэтгүүл зүй, олон нийтийн комисс, иргэдийн зөвлөлийн үйл ажиллагаа багтжээ.

108.

Зориг сан, 2004, “Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт (мониторингийн судалгаа)”

Ном, 114 хуудас, монгол

Энэхүү судалгааг Д.Ганхуяг ахлагчтай 14 судлаач явуулсан бөгөөд мэдээлэл цуглуулах ажилд МУИС-ийн социологийн ангийн нэр бүхий оюутнууд оролцсон ажээ. Мониторингийг Partnership for transparency Fund-ийн санхүүжилтээр Зориг сан захиалан хийлгүүлж, 2004 онд тайланг хэвлүүлсэн байна. Энэхүү номыг Зориг сангийн номын сан, нийтийн номын сангууд болон www.zorigfoundation.org.mn, www.anticorruption.mn вэбсайтуудаас үзэж болно.

Мониторинг хийхдээ дараах дөрвөн аргыг зэрэгцүүлэн хэрэглэсэн байна: 1. Өмнөх судалгаануудаар авилгалд өртөмтгйд тооцогдсон яам, агентлагийн үйл ажиллагаанд бичиг баримтын шинжилгээ хийх, 2. Төр, иргэний хоорондох харилцаанд үүсч буй авилгалын талаар эксперт бүлгээс фокус-группын аргаар судалгаа авч үнэлгээ хийх, 3. Албан болон албан бус баримт материалд гүнзгийрүүлсэн анализ хийх, 4. Авилгалын талаар мэдрэмж, авилгалын хэв загварыг тодорхойлох зорилгоор санал асуулга явуулжээ. Энэхүү санал асуулгад Нийслэл Улаанбаатар, Ховд, Дорнод, Дорноговь, Орхон аймагт 2003 оны 10-11 сард 1286 респондентоос анкет сурвалжлагын аргаар анхдагч мэдээлэл авч, боловсруулалтыг SPSS-8 программаар гүйцэтгэжээ.

109.

НҮБХХ, 1999. “Авилгалтай тэмцэхэд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт уулзалт ярилцлага дээр хийгдсэн илтгэл, мэдээллүүд

Өгцүллүд, 41 хуудас, монгол

УИХ-ын архив, Д№5 ХН №1-д хадгалагдаж байна.

Энэхүү ярилцлага нь НҮБХХ-ийн шугамаар уригдан ажилласан гадаадын шинжээчдийн зөвлөж санал болгосон Авилгалын эсрэг үйл ажиллагаанд нийгмийн оролцоог хангахад чиглэсэн хамгийн анхны алхам байв. Хоёр өдөр үргэлжилсэн энэ ярилцлага дээр сонирхлын олон бүлгийг төлөөлсөн хүмүүс Монгол дахь авилгалын талаар өөрийн бодол санааг чөлөөтэй илэрхийлж, болсон тохиолдлыг баримт буюу ажиглалтаа түшин ярьцгааж байсан юм.

110.

Нийгмийн дэвшил-Эмэгтэйчүүд хөдөлгөөн, 2001. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нээлттэй байдал-иргэдийн оролцоо

Тайлан, 44 хуудас, монгол

Судалгааг Нийгмийн дэвшил-Эмэгтэйчүүд хөдөлгөөн санаачлан Азийн сангийн санхүүжилтээр Архангай, Төв, Өмнөговь, Хэнтий, Багануурт явуулан үр дүнг 2001 онд ийнхүү хэвлүүлжээ.

ИТХ-ын нээлттэй байдалд холбогдуулан анкетын судалгаа явуулсан ба орон нутагт шийдвэр гаргагчид, ИТХ, ЗДТГ-ын ажилтнууд, иргэд, ТББ, бизнес эрхлэгчдийн төлөөлөгчдийг оролцуулан тухайн нутагт тулгамдсан асуудлын талаар уулзалт ярилцлага зохион байгуулж улмаар шийдвэр гаргах журамд өөрчлөлт оруулах санал боловсруулжээ. Тайланд энэ туршлагыг тусгажээ.

111.

Felisa Tibbits, HREA, 2001. “Report on mission to help establish anti-corruption education campaign with MFOS”.

Фелиса Тиббитс, 2001. Монголын Нээлттэй Нийгмийн Хүрээлэнтэй хамтран Авилгалын Эсрэг боловсролын кампанит ажлыг эхлүүлэхэд туслах томилолтын тайлан

Тайлан, 13 хуудас, англи

Уг тайланд авилгалын эсрэг боловсролыг Монгол дахь олон улсын байгууллагууд болон ТББ-уудтай хамтран олон нийтэд хүргэх ажлыг эхлүүлэхээр тус байгууллагуудын төлөөлөгчидтэй уулзаж ярилцсан талаар тусгажээ. Мөн уулзалтынхаа товч тэмдэглэлийг оруулсан бөгөөд ТББ-ууд болон Олон Улсын Байгууллагуудаас авилгалын эсрэг хийж буй ажлын талаархи мэдээлэл, цаашид хийж болох үр ашигтай ажлын саналуудыг оруулжээ. Мөн ард иргэдийг гэгээрүүлэх замаар авилгалтай хэрхэн тэмцэж болох талаархи гол чиг баримтлалуудыг санал болгосон байна.

Уг тайланг авилгалтай тэмцэх сонирхолтой ТББ-ууд болон олон улсын байгууллагууд мөн авилгалын талаархи судалгаа хийж буй судлаачид тодорхой мэдээлэл авах зорилгоор ашиглавал тустай байх болно.

112.

Хүний Эрх Хөгжил Төв, Global Rights, ННФ, 2004. “Хүний эрхийн стратегийн нөлөөлөл: Туршлага ба амжилт” семинар

Илтгэлүүдийн эмхэтгэл, 84 хуудас, монгол

Энэхүү семинарын илтгэлүүдийн эмхэтгэлийг ННФ-ын www.forum.mn вэбсайт

болон Хөгжлийн мэдээллийн төвөөс авч үзэж болно.

Хохирогчийг шүүхээр хамгаалах, зөрчигдсөн эрхийг хамтран хамгаалах, үндсэн хуулийг хамгаалах зэрэг асуудлаар ТББ-уудын төлөөлөгчид, өмгөөлөгч болон бие даасан шинжээч нар явуулсан тодорхой үйл ажиллагааныхаа талаар туршлага солилцоход туслах зорилгоор уг семинарыг зохион байгуулжээ. Илтгэлүүд нь болсон үйл явдал түүнд хэрхэн нөлөөлсөн тухай юм.

113.

“Өнөөдөр” сонин, 2004. Ч.Баяр “Эрдэмтнийг дэмжсэн иргэний үг”

Өгцлэл, 2004.01.28 №22, 17-р нүцрт

Хан-Уул дүүргийн наймдугаар хорооны иргэн Ч.Баяр нь “Хүний аюулгүй байдал сайн засаглал” хөтөлбөрийн үндэсний менежер Д.Цэрэндоржийн “Өнөөдөр” сонинд өгсөн ярилцлага, дүгнэлт санал, шүүмжлэлийн талаар өөрийн санал бодлоо илэрхийлжээ.

“...Нийгмийн шаардалагад нийцсэн сайн хууль гаргахгүй байгаа тухай УИХ-д хандсан эрдэмтний энэ шүүмжлэл нь шударга иргэд сонгогчдын сэтгэлийн шаардлага болж байгааг УИХ-ын эрхэм гишүүд ойлгож, ирэх чуулганаас тэр хууль батлагдан гарах байх гэж найдна. Хэрэв тэр боловсруулагдсан сайн хууль батлагдан гарвал хэн ч бай авлига өгөх, авахаас эмээдэг, авахаас бол бүр айдаг байх тийм нөхцөл бий болох ёстой.”

4

АВИЛГАЛ БА
ХУВИЙН ХЭВШИЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

114.

“Монголын өмч хувьчлал” хөтөлбөр, 2000. Хувьчлал: түгээмэл асуулт, бодитой хариулт

Ном, 155 хуудас, монгол

Уг номыг “Баренц” бүлгээс эрхлэн 2000 онд “Монголын өмч хувьчлал” хөтөлбөрийн хүрээнд хэвлүүлжээ. Зориг сангийн номын сан, нийтийн номын сангуудаас авч үзэж болно.

Баренц бүлэг нь Монголын засгийн газрын урилгаар, ТӨХ-нд өмч хувьчлалын асуудлаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, их хувьчлалд орох объектуудад аудит хийх үүрэгтэй ажиллаж байв. Тус бүлгийн үйл ажиллагааг АНУ-ын Олон улсын Хөгжлийн Агентлагаас санхүүжүүлж байжээ. Энэхүү товхимолоос Монголд явагдсан өмч хувьчлалын эргэн тойронд болж байсан мэтгэлцээний талаар мэргэжлийн түвшинд боловсрогдсон мэдээлэл олж авах боломжтой.

115.

**Үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулалт төсөл II үе шат, 2004. Монгол Улс: Бизнесийг дэмжих таатай орчны бүрдүүлэлтийн судалгаа
Enterprise Restructuring Project Phase II, 2004. Mongolia: A Scan of the Business Enabling Environment, Report**

Судалгааны тайлан, 114 хуудас, монгол, англи

Энэхүү судалгааг Бээжин дэх Нидерландын Вант улсын ЭСЯ-ны санаачлага, дэмжлэгтэйгээр Үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулалт төслийн судалгааны тайлан. Судалгааг хэвлэмэл болон электрон форматаар Ерөнхий сайд Амарын гудамж 1, НИК ХК-ийн байр 1-р давхар, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот хаягаар Үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулалт төслийн байрнаас болон www.enterprise-restructuring.com вэбсайтаас авч болно.

Энэхүү төслийг Монгол улсын хувийн хэвшил цаашид ямар чиглэлд ажиллах шаардлагатай байгааг тодорхойлохын тулд хэрэгжүүлжээ. Судалгаанд нийт 100 гаруй аж ахуйн нэгжийг хамруулан, бизнес эрхлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээлүүд болон тэдгээрийг шийдэх арга замуудын талаар асуусан байна. Судалгаанд оролцогчид авилгалыг бизнес хөгжүүлэхэд тээг болж буй 12 саад бэрхшээлээс хоёрдугаарт татварын дараа нэрлэжээ.

116.**Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ), 2000.
“Бизнесийн хүрээн дэх авилгал”**

Судалгааны тайлан: 35 хуудас, монгол

Хувийн хэвшлийнхэн болон бизнес эрхлэгчдийн ашиг сонирхолыг төлөөлөн Азийн сангийн санхүүжилтээр МҮХАҮТ, Зах Зээл Судлалын Хүрээлэнтэй хамтран хийжээ.

Энэхүү судалгааг 2000 оны 1-3-р сар хүртэлх хугацаанд Улаанбаатар хот болон 14 аймгийн /Ховд, Орхон, Архангай, Хөвсгөл, Дорнод, Хэнтий, Булган, Баян-Өлгий, Дундговь, Дорноговь, Увс, Говьсүмбэр, Өмнөговь, Дархан-Уул/ бизнес эрхлэгчдийн дунд явуулсан бөгөөд нийт 952 хүнийг хамруулсан байна.

“...Улс орны эдийн засгийн хөгжлийг саатуулагч нэг гол хүчин зүйл болох авилгалын асуудал өнөөдөр манай нийгмийн хамгийн тулгамдсан асуудал болж байгаа нь хэн бүхний сэтгэлийг зовоож байна. Хэдийгээр урьд өмнө нь манайд авилгал байсан боловч өнөөдрийнх ишг өргөн хүрээнд тархаж олон нийтийг хамарсан хэмжээнд хүрээгүй байсан билээ. Нэн ялангуяа бизнес хөгжих, бизнесийн эрцүл орчинг бий болгоход авилгал маш их саад учруулж байгааг судлах зорилгоор энэхүү санал, асуулгыг явуулсан.”

122.**Нээлтэй Нийгэм Форум, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадварын төсөл 2005. “Монгол улсын албан бус секторын хамрах хүрээ, төлөв байдал”**

The Open Society Forum, (OSF) Ulaanbaatar, Mongolia and United States Agency for International Development USAID 2005. “The size and character of the informal sector and its shadow economy in Mongolia”

Үндсэн тайлан: 97 хуудас, монгол, англи

ННФ, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн Эдийн засгийн бодлогын шинэтгэл, өрсөлдөх чадварын төсөлтэй хамтран энэхүү судалгааны тайланг ННФ-ын Хөгжлийн Мэдээллийн төвөөс авч үзэж болно. Вебсайт: www.forum.mn, Имэйл: osf@soros.org.mn

Судалгааны онцлог нь албан бус сектор дахь бүртгэлгүй буюу сүүдэр үйл ажиллагааны хэмжээг тогтоох, улмаар өнөөгийн тооцож буй Дотоодын Нийт Бүтээгдэхүүнийг илүү бодитой тооцох үндэс суурийг гаргахад оршино. Түүнчлэн уг салбарт ажиллагсдын төлөв байдал, хоорондын болон албан салбартай харилцах явдалд дүн шинжилгээ хийснээр цаашид төр засаг хувийн хэвшлийн эдийн засгийг дэмжих бодлогоо улам боловсронгуй болгох бололцоог олгох юм. Судалгаа нь бодлого боловсруулагчид, эдийн засагчид, судлаачид, оюутнууд мөн эл салбарт ажиллагсад болон олон нийтэд маш дэлгэрэнгүй

мэдээлэл өгөхөөс гадна судалгааны шинэлэг арга зүй, сонирхолтой шийдлүүдээр дүүрэн байсан.

118.

Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо, 2001. “Авилгалын эдийн засгийн өртөг” судалгаа

Судалгааны тайлан, 25 хуудас, монгол

НҮБХХ-ийн санхүүжилтээр хийгдсэн уг судалгааг С.Дэмбэрэл /МҮХАҮТ/, доктор Н.Лувсанжав /Хэлцэл хууль зүйн товчоо/, Ж.Бямбаа /Нийслэлийн шүүх/ зэрэг судлаач нарын бүрэлдэхүүнтэй баг хийсэн ба Улаанбаатар, Замын-Үүд, Ховд аймгийн Булган суманд нийт 1500 хүмүүсээс судалгаа авсан. Зориг сангийн номын сан болон www.anticorruption.mn вэбсайтаас авч үзэж болно.

Оролцогчдоос дараах 3 төрлийн санал асуулга авсан байна. 1. Олон нийтийн дунд, 2. Аж ахуй эрхлэгч, судлаачдын дунд, 3. Хуульчдын дунд. Энэхүү судалгаа нь авилгалын эсрэг тэмцэх үндэсний бодлого боловсруулах, төр, засгийн зүгээс энэхүү ажлын хүрээнд явуулж буй үйл ажиллагаанд тусламж дэмжлэг үзүүлэхүйц мэдээлэл цуглуулах, авилгалын сөрөг үр дагавар, түүний эдийн засгийн өртгийг тодорхойлох зорилготой.

119.

Олон улсын бизнесийн үйл ажиллагаанд гадаадын төрийн албан тушаалтныг хахуульдах явдалтай тэмцэх тухай конвенци (товчоор, OECD-гийн конвенци, 1997.5.23-нд батлагдсан)

Конвенци, 8 хуудас, монгол

Энэхүү Конвенцийн албан бус монгол орчуулга, түүнд холбогдох тайлбар болон Авилгалын эсрэг хуулийн 1999.05.16-ны төсөлд өгөх саналаа Гадаад Харилцааны Яамны Эрх зүйн хэлтсээс УИХ-ын Ажлын хэсэгт ирүүлсэн байна. Эдгээр баримт бичиг УИХ-ын Архивт хадгалагдан үлджээ.

“...Бизнесийн үйл ажиллагаанд оршиж буй хахуульдах үзэгдэл хэдийнээ цндэстэн дамнасан шинжтэй болчихоод байхад хууль эрхийн актууд нь цндэстний хил хязгаарт баригдсан хэвээр байгаа нь авилгалын эсрэг тэмцлийг олон улсын тавцан дээр хүчгүйдүүлж байлаа. Конвенцийн гол үзэл баримтлал нь хууль эрхийн энэхүү хийдлийг зохицуулах механизмыг бүрдүүлэхэд чиглэсэн юм.”

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

5

АВИЛГАЛ БА
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

120.

Глоб Интернэйшл, 2005, 2005 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн хэвлэл мэдээллийн мониторингийн дүн

Судалгааны дүн, 8 хуудас, монгол

АНУ-ын Үндэсний Ардчилсан Хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр Глоб Интернэйшл ТББ хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 2005 оны 5-р сарын 22-нд болсон Ерөнхийлөгчийн сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн мониторингийг хийсэн тухай энэхүү судалгааны дүнгээс мэдэж болно. Энэхүү мониторинг нь иргэдийг мэдээлэлтэй сонголт хийхэд нэр дэвшигчид болон тэдний мөрийн хөтөлбөрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хэр бодитой, тэнцвэртэй мэдээлэл хүргэж байгааг үнэлэх зорилготой бөгөөд сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхэлсэн өдрөөс эхлэн 6 телевиз, 1 радио, 4 өдөр тутмын сонинг хамруулжээ.

121.

Ж.Нэргүй, 2003. “Төрөө завхруулж, түмнээ хуурсан шаштир- I, II”

Ном, I боть 80 хуудас, II боть 88 хуудас монгол

УИХ-ын 2004 оны сонгуулийн өмнө өдөр тутмын сонинуудад гарсан авилгалын талаарх зарим материалуудыг сэтгүүлч Ж.Нэргүй эмхэтгэн хоёр ном болгон хэвлүүлжээ.

122.

Ч. Базар, 2003. “Хэрхэн эрэн сурвалжлага хийх вэ?”

Ном, 135 хуудас, монгол

Ч.Базарын бүтээлийг Зориг сангийн номын сан болон www.zorigfoundation.mn, www.anticorruption.mn вэбсайтуудаас авч үзэж болно.

Монгол дахь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, түүний цаашдын төлөвийг тодорхойлох оролдлого хийсэн байна. Тус ном “Эрэн сурвалжлах арга барил”, “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй ба Монголын хөрс”, “Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол дадлага” гэсэн гурван бүлэгтэй. Сэтгүүлч, сэтгүүл зүйн оюутнуудад зориулсан ном юм.

123.

Зориг сан, 2004. “Ерөнхийлөгчийг огцруулсан сэтгүүлчийн нөр их хөдөлмөр” (эрэн сурвалжлах сэтгүүлчдэд зориулсан гарын авлага).

Гарын авлага, 92 хуудас, монгол орчуулга

Зориг сангийн номын сан болон www.zorigfoundation.mn, www.anticorruption.mn вэбсайтуудаас авч үзэж болно.

Филлипин улсын ерөнхийлөгч Эстрадагийн авилгалыг илчлэн түүнийг огцруулахад хүргэсэн Филлипины Эрэн Сурвалжлах төвийн үйл ажиллагааг Дэлхийн Банкны Хүрээлэнгээс гарын авлага болгон гаргасныг ЮНЕСКО-гийн санхүүжилтээр Зориг сангаас монгол хэлнээ хөрвүүлэн ном болгон хэвлэсэн юм.

Монгол улсад эрэн сурвалжлах сэтгүүл зүйг шинээр хөгжүүлэхэд гарын авлага болох чухал ном юм. Сэтгүүл зүйн салбарын оюутан, сэтгүүлч судлаачдад хэрэгтэй бүтээл.

124.

Зориг сан, 2001. “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй -1”

Төслийн тайлан: 2 хуудас, монгол, англи

НҮБХХ-ийн санхүүжилтээр хэрэгжсэн уулзалт семинарийн тайланг Зориг сангийн номын сан болон www.zorigfoundation.mn, www.anticorruption.mn вэбсайтуудаас авч үзэж болно.

Монгол улсад эрэн сурвалжлах сэтгүүл зүйн чиглэлээр хийгдсэн анхны туршлага судлах уулзалт семинар бөгөөд хот хөдөөгийн нийт 112 сэтгүүлч сурвалжлагчдыг хамруулсан. Семинарын багшаар АНУ-ын сэтгүүлч, Жапан Таймс сонины сурвалжлагч Эрик Жонстон ажиллаж өөрийн мэдлэг туршлагаасаа хуваалцсан юм.

125.

Зориг сан, 2001. “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй-2”

Төслийн тайлан: 4 хуудас, монгол, англи

Канад сан, Люксембургийн ЭСЯ-ны санхүүжилтээр хэрэгжсэн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сургалтын төслийн тайланг Зориг сангийн номын сан болон www.zorigfoundation.mn, www.anticorruption.mn вэбсайтуудаас авч үзэж болно.

Энэ нь Зориг сангаас хэрэгжүүлсэн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хоёр дахь шатны сургалт бөгөөд Дэлхийн Банкны зөвлөх Канадын сэтгүүлч Родерик МасДонелл багшаар ажилласан. Сургалтыг Дэлхийн Банкны Хүрээлэнгээс гаргасан эрэн сурвалжлах сэтгүүл зүйн хичээлийн дагуу зохион байгуулсан байна. Нийт хот хөдөөгийн 42 сэтгүүлчдэд 28 цагийн хичээл заасан байна.

126.

**Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ), 2003,
“Авилгалын эсрэг тэмцэлд ТББ-уудын оролцоог нэмэгдүүлэх нь” төслийн
эцсийн тайлан**

Төслийн эцсийн тайлан: 23 хуудас, монгол

МННХ-ийн санхүүжилтээр МҮХАҮТ-аас 2001 оны 12-р сараас 2003 оны 1-р сар хүртэлх хугацаанд 3 үе шаттайгаар хэрэгжүүлсэн төслийн эцсийн тайланд энэхүү төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй бичжээ. Үүнд: Авилгалын индекс судалгаа ба түүнийг эмхэтгэл болгон олон нийтийн хүртээл болгосон, Хэвлэл мэдээллийн ажилтнуудад зориулсан нэг өдрийн семинар, Семинарт уншсан лекцүүдийг эмхэтгэл болгон хэвлэн гаргасан, Авилгалын индекс судалгааны үр дүнгийн талаарх уулзалт ярилцлага зохион байгуулсан болон Авилгалын эсрэг ТББ-уудын эвсэл байгуулсан тухай зэрэг мэдээллүүд багтжээ.

127.

**Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ), 2002.
“Авилгалын эсрэг тэмцэлд хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоог
эрчимжүүлэх нь”**

Эмхэтгэл: 25 хуудас, монгол

МННХ-ийн санхүүжилтээр МҮХАҮТ-аас 2001 оны 12-р сараас 2003 оны 1-р сар хүртэлх хугацаанд 3 үе шаттайгаар хэрэгжүүлсэн төслийн хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудын дунд зохион байгуулсан сургалт семинар дээр уншсан лекцүүдийн эмхэтгэл. Үүнд: С.Нарангэрэл “Авилгалын эсрэг хууль эрх зүйн орчин, түүний хэрэгжилт”, Ц.Дашдондов “Авилгалтай хийх тэмцэлд хэвлэл мэдээллийн байгууллагын гүйцэтгэх үүрэг”, Д.Ламжав “Авилгалтай тэмцэх арга замууд”, Ц.Бат-Орших “Эрэн сурвалжлах сэтгүүл зүй ба авилгал”, Ч.Нэргүй “Монгол дахь авилгалын өнөөгийн байдал” лекцүүд багтжээ.

128.

Зориг сан, 2002. “Өнөөдөр эсвэл хэзээ ч ...”

Эмхэтгэл, монгол хэл

Ил тод байдлын төлөө түншлэл сан (Partnetship for Transparency Fund)-гийн санхүүжилтээр хэрэгжсэн авилгалын эсрэг зурагт хуудас, сонины нийтлэл, радио телевизийн ролик болон нэвтрүүлгийн уралдааны төслийн тайланг Зориг сангийн номын сан болон www.zorigfoundation.mn, www.anticorruption.mn вэбсайтуудаас авч үзэж болно.

Төслийн хүрээнд зохион байгуулагдсан уралдаанд хот хөдөөгийн нийт 450-иад иргэдийн 411 бүтээл ирсэн бөгөөд шалгарсан бүтээлүүдэд шагнал олгож олны хүртээл болгосон. Мөн уралдаанд ирсэн зурагт хуудас, сонины нийтлэлүүдийг эмхэтгэл болгон МННХ-гийн санхүүжилтээр хэвлүүлсэн. Энэхүү эмхэтгэлийг ННФ-ын Хөгжлийн Мэдээллийн Төвөөс үзэх боломжтой.

МАТЕРИАЛЫН АНГИЛАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НОМ.

	Нэрс	Зохиолч, хаанаас гаргасан	Төрөл	Хэвлэгдсэн он, хуудас
АВИЛГАЛЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ СЭДЭВ				
001	Авилгалын эсрэг сурвалж бичиг	Жереми Поуп	Ном орчуулга	2003 он 450 хуудас
002	Авилгал түүний ойлголт, тэмцэх арга зам	Зориг сан	Ном, семинарын эмхэтгэл	2000 он 40 хуудас
003	Үндэсний шударга ёсны тогтолцоо, түүний үзүүлэлтүүд	Монголын Засгийн газрын ХАБХСЗ хөтөлбөр	Ном	2003 он 228 хуудас
